



МОНГОЛБАНКНЫ МЭДЭЭЛЭЛ



Монголбанкны үндсэн зорилт нь үндэсний мөнгөн тэмдэгт - төгрөгийн тогтвортой байдлыг хангахад оршино.

2018 • VIII • № 22

**Б.ЛХАГВАСҮРЭН:
САНХҮҮГИЙН СУУРЬ
МЭДЛЭГ ОЛГОХ
ХИЧЭЭЛИЙГ ДУНД
СУРГУУЛИЙН ЗААВАЛ
СУДЛАХ ХИЧЭЭЛИЙН
ТООНД ОРУУЛАХААР
ЗАСГИЙН ГАЗАРТАЙ
ХАМТРАН АЖИЛЛАНА**

**ЭРДЭС БАЯЛГИЙН
САЛБАРТ НЭГДСЭН
ЦАХИМ БҮРТГЭЛИЙГ
УЛС ОРНУУД ӨРГӨН
АШИГЛАЖ БАЙНА**

ЗӨВХӨН АЛБАН ХЭРЭГЦЭЭНД

МОНГОЛ УЛСЫН
ӨРДЭНЭСИЙН САНГААС: ГОЛТ ЦӨГЦ

ИНФЛЯЦИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ШАЛТГААН

Хэрэглээний үнийн индексээр илэрхийлсэн инфляци 2018 оны 7 дугаар сарын байдлаар Улсын хэмжээнд 7.7 хувь, Улаанбаатар хотод 8.8% байв. Инфляци сүүлийн 2 сард идэвхжихэд хатуу түлш (хэрэглээний нүүрс, мод), мах, хүнсний ногоо болон шатахууны үнийн өсөлт нөлөөлж байна. Эдгээр 4 төрлийн бүтээгдэхүүн Улаанбаатар хотын жилийн инфляцийн 4.6 нэгж хувийг дангаараа тайлбарлаж байна.

Улаанбаатар хотын жилийн инфляцийн бүрэлдэхүүн




Цаг агаарын нөхцөлөөс үүдэн **хатуу түлшний** үнэ өнгөрсөн оны 8-11 дүгээр сар болон 2018 оны 1-3 дугаар сард нийт 60.6 хувь өссөн нь улирлын хандлагаас давсан үзүүлэлт байв.

Махны үнэ 6 дугаар сарын дунд хүртэл өсч, оны эцэс рүү хямдардаг улирлын хандлагаасаа зөрж 7 дугаар сарын дунд хүртэл өссөнөөр 6 болон 7-р сард инфляци өсөх нөлөөг үзүүллээ.

Өнгөрсөн онд ургац тааруу (төмс, хүнсний ногооны ургац 2016 онтой харьцуулахад 20-40 хувиар буурсан) байсны нөлөөгөөр **хүнсний ногооны** үнэ өмнөх оны мөн үеэс 10-50 хувийн өндөр түвшинд хадгалагдаж байна. Тухайлбал, хүнсний ногооны бүлгийн үнэд хамгийн их нөлөөтэй бүтээгдэхүүн болох төмсний үнэ өмнөх оны мөн үеэс 85.3 хувь, луувангийн үнэ 138.1 хувь, байцааны үнэ 39.5 хувиар өндөр байна. Өмнөх жилүүдийн онцлогоос харахад үнэ шинэ ургац хураалттай холбоотой 7, 8-р сард буурдаг.

Дэлхийн зах зээл дээрх **нефтийн** бүтээгдэхүүн болон Монгол Улсад импортолж буй шатахууны хилийн үнэ 40 орчим хувиар өссөнөөс шалтгаалан дотоодын зах зээлд шатахууны үнэ өнгөрсөн оны мөн үеэс 250 орчим (тайлант оны 5-7 дугаар сард 130 орчим) төгрөгөөр нэмэгдлээ.

Инфляцийн богино хугацааны төсөөлөл



Нийлүүлэлтийн шокод өртөмтгий бараа, бүтээгдэхүүнийг хэрэглээний сагснаас хасч тооцсон суурь инфляци оны эхнээс 3.1 хувь, өмнөх оны мөн үеэс 7.5 хувь өссөн байна.

Монголбанкны Олон нийтийн боловсрол, мэдээллийн төвөөс эрхлэн гаргав.

Онцлох үйл явдал:

Төрийн байгууллагууд алт худалдан авалтыг нэмэгдүүлэх арга замын талаар хэлэлцлээ

ХУУДАС

4

Ярилцлага:

БЛХагвасүрэн: Санхүүгийн суурь мэдлэг олгох хичээлийг дунд сургуулийн заавал судлах хичээлийн тоонд оруулахаар Засгийн газартай хамтран ажиллана

ХУУДАС

7

Байр суурь:

Алтны арилжааны талаар Олон Улсын шинжээчид юу хэлэв?

ХУУДАС

12

Нийтлэл:

Эрдэс баялгийн салбарт нэгдсэн цахим бүртгэлийг улс орнууд өргөн ашиглаж байна

ХУУДАС

17

Улаанбаатарын зөвшилцөл:

Нэг салбараас хэт хамааралтай эдийн засаг нь тухайн салбар уналтад ороход дагаж унах том эрсдэлтэй

ХУУДАС

19

Асуулт, хариулт:

Монголбанкны хэвлэлийн бага хурлаас... /2018.08.29/

ХУУДАС

24

Банкир:

Рэндолф Коппа: Банкир ч гэлтгүй аливаад "хэрэв" гэсэн өнцгөөр хардаг байвал сайн

ХУУДАС

29

Эрдэнэсийн сан:

Голт цөгц

ХУУДАС

34

Судалгаа:

Зээлийн хүүг бууруулах стратегийн үндэслэл, шаардлага

ХУУДАС

35

Дэлхийн үйл явдал:

Кени Улс зээлийн хүүндээ хязгаар тавьсан нь эдийн засагтаа тушаа болж байна

ХУУДАС

38

Санхүүгийн боловсрол:

Банкны үйл ажиллагаа, яагаад бид банктай харилцдаг вэ?

ХУУДАС

41

Зээлийн мэдээллийн сангаас зарим иргэний мэдээллийг хэвийн ангилалд шилжүүлээ

2018.08.01

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны 8 дугаар сарын 01-ний өдрийн А-209 тоот тушаалаар иргэний зээлийн мэдээллийн лавлагаанд хамаарах мэдээллийн нөхцөлд нэмэлт оруулж баталлаа. Уг нөхцөлд 2018 оны 6 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө санхүүгийн түрээс (лизинг)-ийн төлбөр нь бүрэн төлөгдөж дууссан, нэг удаагийн хугацаа хэтэрсэн болон чанаргүй санхүүгийн түрээсийн төлбөрийн түүхтэй иргэний Монголбанкны "Зээлийн мэдээллийн сан" дахь сөрөг түүхийг хэвийн ангилалд шилжүүлэхээр болсон юм. Уг шийдвэрийн дагуу нийт 14170 иргэний мэдээлэл шаардлага хангасан байна.



Технологид суурилсан санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний хөгжлийн талаар хэлэлцүүлэг хийв

2018.08.03



Монголбанк технологийн компаниудыг оролцуулсан "Технологийн дэвшил, шинэ ололтод суурилсан санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний цаашдын төлөв ба шаардлагатай зохицуулалт" сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгууллаа. Хэлэлцүүлгийг Монголбанкны Мөнгөний бодлогын газар удирдаж, And global, Mobi finance, Lab fintech Mongolia, КК ТТ, Itools, компаниуд болон Монголын банкны холбоо оролцон, өөрсдийн нэвтрүүлж буй шинэлэг технологийн шийдлүүдийн талаар танилцууллаа. Мөн үеэр санхүүгийн үйлчилгээний хүртээмж, түргэн шуурхай, аюулгүй найдвартай байдлыг хангах, технологийн шинэ ололтод тулгуурласан шинэ бүтээгдэхүүн бий болгох талаар санал солилцлоо.

Монголбанкны Ерөнхийлөгч ОУВС-ийн Монгол Улсыг хариуцсан гүйцэтгэх захирлыг хүлээн авч үүлэв

2018.08.06

Уулзалтын эхэнд Монголбанкны Ерөнхийлөгч Н.Баяртсайхан ноён Хохюн Жанд шинэ албан тушаалд томилогдсонд нь баяр хүргэхийн сацуу Монгол Улсад хэрэгжиж байгаа Олон Улсын Валютын Сангийн "Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр"-ийн хэрэгжилтийн талаар мэдээлэл солилцов. Гүйцэтгэх захирал ноён Хохюн Жанын зүгээс хөтөлбөрийн хэрэгжилтэд сэтгэл хангалуун байгаагаа тэмдэглээд 5 дахь шатны үнэлгээний үр дүнг удахгүй ОУВС-ийн Захирлуудын зөвлөлөөр хэлэлцэхээ мэдэгдсэн билээ.



Монголбанкны Дэд Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн “Алт үйлдвэрлэгчдийн холбоо”-ны удирдлагуудтай уулзлаа

2018.08.06




“Эх орныхоо алтыг Эрдэнэсийн сандаа” аяны хүрээнд Монголбанкны Дэд Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн “Алт үйлдвэрлэгчдийн холбоо”-ны төлөөлөлтэй уулзалт хийлээ. Уулзалтын үеэр алт үйлдвэрлэгчдийн холбоо Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 17.1-д “3,0 тэрбум төгрөгнөөс дээш албан татвар ногдуулах жилийн орлого олсон бол 300,0 сая төгрөг, 3,0 тэрбум төгрөгнөөс дээш давсан орлогын дүнгийн 25 хувиар нэмж албан татвар ногдуулна.” гэж заасан нь алт олборлогч компаниудад татварын дарамтыг нэмэгдүүлдэг, мөн зарим тохиолдолд лицензийг хүчингүй болгосноор алт олборлолтын үйл ажиллагаа удааширдаг, холбогдох газруудын зүгээс олон удаа шаардлагагүй хяналт шалгалт хийдэг, иргэд, төрийн албан хаагчдыг алт, алт олборлолтын талаар зөв ойлголттой болгох зэрэг асуудлуудыг дурдлаа.

Монголбанкны Ерөнхийлөгч Н.Баяртсайхан Дэлхийн банкны Монгол, Солонгос, Хятад улсыг хариуцсан захирал Берт Хофманыг хүлээн авч уулзлаа

2018.08.07

Уулзалтаар Монгол Улсад хэрэгжиж байгаа Олон Улсын Валютын Сангийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр” болон Дэлхийн банкны “Эдийн Засгийн удирдлагыг дэмжих хөгжлийн бодлогын хөтөлбөр”-ийн хэрэгжилт, манай улсын эдийн засагт гарч буй эерэг өөрчлөлтийн талаар санал солилцлоо. Ноён Берт Хофманд Монголбанкны зүгээс эдгээр хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлж байгаад талархсанаа илэрхийлсэн юм.



ОУВС-аас өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн тав дахь шатны үнэлгээг хийж дууслаа

2018.08.08



Энэ удаагийн буюу 5 дахь шатны үнэлгээг Жэф Готтлийбээр ахлуулсан ОУВС-ийн ажлын хэсэг гүйцэтгэлээ. Тус ажлын хэсэг 2018 оны 07-р сарын 25-наас 08 дугаар сарын 06-ны өдөр Монгол Улсад ажилласан юм. Тэд энэ үеэр хөтөлбөрийн хэрэгжилт, Засгийн газар, Монголбанкнаас авч хэрэгжүүлж байгаа бодлогын арга хэмжээний хэрэгжилт, тоон үзүүлэлтүүдийн үнэлгээг урьдчилсан байдлаар гаргасан байна. Ажлын хэсэг үнэлгээний дүнг ОУВС-ийн захирлуудын зөвлөлд танилцуулдаг.

Банкны салбарын удирдах ажилтны бүсийн зөвлөгөөн боллоо

2018.08.13

Монголбанкнаас банкны салбарын удирдах ажилтны бүсийн зөвлөгөөнийг зохион байгуулж байна. Өнгөрсөн онд анх хэрэгжүүлж эхэлсэн уг бүсийн зөвлөгөөн энэ жил Хангайн бүсийн зөвлөгөөнөөр эхэлж, 8-р сарын 09-11-нд Хөвсгөл аймагт, Баруун бүсийн зөвлөгөөн 8-р сарын 22-25-нд Говь-Алтай аймагт боллоо. Зөвлөгөөнөөр “2017 онд хэрэгжүүлсэн төрийн мөнгөний бодлогын үр дүн”, “2018 онд баримтлах үндсэн чиглэл, Банкны салбар дахь технологийн чиг хандлага: Fintech”, “Мөнгөн тэмдэгтийн чиг хандлага, асуудлууд”, “Судалгаа шинжилгээ, мэдээ тайлангийн дүнг зорилтот хэрэглэгчдэд оновчтой хүргэх нь” зэрэг илтгэлийг хэлэлцүүлэн бүсийн банкны салбарын ажилтнуудын ур чадварыг нэмэгдүүлэх, туршлага солилцох уулзалт хийлээ.



Төрийн байгууллагууд хамтран алт худалдан авалтыг нэмэгдүүлэх арга замын талаар хэлэлцлээ

2018.08.27



Монголбанк “Эх орныхоо алтыг Эрдэнэсийн сандаа” аяны хүрээнд Уулзуурхай хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмал, газрын тосны газар, Тагнуулын Ерөнхий газар, Цагдаагийн Ерөнхий газар, Гаалийн Ерөнхий газрыг оролцуулсан уулзалт хэлэлцүүлгийг зохион байгуулав. Оролцогчид “Монгол Улсын алтны үйлдвэрлэлийн хэтийн төлөв”, “Улсын хилээр алт хууль бусаар нэвтрүүлэх гэмт хэргийн нөхцөл байдал, урьдчилан сэргийлэх арга зам”, “Алт улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэх зөрчлийн арга хэлбэр ба тулгамдаж буй асуудал” сэдвээр илтгэл тавьж танилцуулав. Мөн төрийн байгууллагын уялдаа холбоог сайжруулах, цаашдын хамтын ажиллагааны талаар нээлттэй хэлэлцсэн юм.

“МӨНГӨ-САНХҮҮ-БАЯЛАГ” СЭТГҮҮЛИЙН ДОЛОО ДАХЬ ДУГААР ХЭВЛЭГДЛЭЭ

2018.08.27

Эдийн засгийн судалгаа, шинжилгээний “Мөнгө-Санхүү-Баялаг” сэтгүүлийн энэ удаагийн дугаарт УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооноос бэлтгэсэн “Эдийн засгийн хүндрэлийг давж, өсөлтийг дэмжих зорилт, цаашдын чиг хандлага” нийтлэл, “Монгол Улсын тогтвортой, хүртээмжтэй өсөлтийн зарим асуудалд”, “Орчин үеийн мөнгө, санхүүгийн диалектик: улс төрийн эдийн засгийн талаас судлахуй” өгүүлэл (орос хэл дээр), “Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдал” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлаас гаргасан зөвлөмж, “БНМАУ-ын Банкны хууль нь эдийн засагт хувьсгал хийсэн хууль мөн” өгүүлэл, зээлийн өндөр хүүний суурь шалтгаан, бизнесийн мөчлөг, зарим улс орнуудын эдийн засгийн аюулгүй байдал зэргийн тухай нийтлэгджээ. Сэтгүүлийн энэхүү дугаарыг эрхлэн гаргахад ШУА-ийн Философийн хүрээлэн, ОХУ-ын Эрхүү хотын Байгалийн улсын их сургууль, Улаанбаатар Эрдэм их сургууль, Голомт, ХААН, Хас банкны судлаач, эрдэмтэн, мэргэжилтэн, УИХ-ын зарим гишүүд хамтран ажилласан байна.



Тантай хийх ээжит ярилцлагынхаа сэдвийг олон нийтийн санхүүгийн боловсролын асуудалд чиглүүлэх хүсэлтэй байна. Хувь хүн санхүүгийн мэдлэг, боловсролтой байх нь эдийн засгийн мэдлэгээс юугаараа ялгаатай тухай та өөрийн бодлоо хуваалцана уу?

-Ер нь л санхүүгийн мэдлэг бол өргөн утгаараа мөнгөтэй холбоотой гаргаж байгаа ямарваа шийдвэр оновчтой байхын тулд мэдээлэл, мэдлэг дээр үндэслэгдсэн түүндээ дүгнэлт хийх чадвар, арга барилтай байхад л болж байгаа хэрэг. Зах зээлийн харилцаанд суурилсан орчин үеийн эдийн засагт санхүү, мөнгөтэй холбоотой маш олон бүтээгдэхүүн үйлчилгээ бий болсоор байна. Энэ хэрээр өдөр тутмын амьдралын алхам бүрт тодорхой сонголт хийх зайлшгүй шаардлага гарч байна. Зөвхөн банкны хадгаламж л гэхэд дотроо маш олон төрөл болохын зэрэгцээ хосолмол хэлбэртэй болсон. Тухайлбал, хөвөгч хүүтэй, эсвэл хадгаламж зээлийн багц гэх мэт. Эдгээрээс аль ашигтайг сонгох нь наад захын асуудал юм.

Дээр нь инфляци, ханшийн нөлөө гэх мэт эдийн засагт өрнөж буй үйл явдал нь таны хадгаламжид хэрхэн нөлөөлөх вэ, банкинд хадгалуулахгүй бол өөр ямар сонголт байна вэ, тэдгээрийн эрсдэл нь юу вэ? Энэ бүхнийг эргэцүүлсний эцэст зөв шийдвэр гаргах чадвартай байх нь маш чухал. Тэгэхээр, санхүүгийн зах зээл дээр байгаа бүтээгдэхүүн үйлчилгээний тухай суурь ойлголтоос эхлээд, эдийн засгийн үзүүлэлтүүдийн харилцан уялдаа хүртэлх цогц мэдлэг, тэдгээрт дүгнэлт хийх чадвар, олсон чадвараа хандлага болгохыг л санхүүгийн мэдлэг гэж ойлгож болно.

Тэгвэл иргэдийн санхүүгийн мэдлэг сайжрах нь аливаа улс оронд ямар ач холбогдолтой вэ. Яагаад ингэж асуух болов гэхээр, 2012 оны дэлхийн нийтийн санхүүгийн хямралын дараа олон улсын санхүүгийн байгууллагууд олон нийтийн санхүүгийн мэдлэг, боловсролд хийгээд харилцагчийн эрх ашигт анхаарлаа хандуулах болсон байдаг шүү дээ.



САНХҮҮГИЙН СУУРЬ МЭДЛЭГ ОЛГОХ ХИЧЭЭЛИЙГ ДУНД СУРГУУЛИЙН ЗААВАЛ СУДЛАХ ХИЧЭЭЛИЙН ТООНД ОРУУЛАХААР ЗАСГИЙН ГАЗАРТАЙ ХАМТРАН АЖИЛЛАНА

*Монголбанкны Дэд Ерөнхийлөгч
Б.Лхагвасүрэнгтэй ярилцлаа*

Олон нийт санхүүгийн мэдлэг ойлголттой байна гэдэг бол нийт эдийн засагт томоохон савлагаа, төөрөгдөл гарахгүй эдийн засаг тогтвортой байх суурь шүү дээ. Үүнийг олон улсад хэрхэн авч үзэж буй талаар нэг л жишээ дурдъя. Олон улсад 2000 оноос хойш эдийн засгийн бодлого тодорхойлогчид санхүүгийн тогтвортой байдлыг дунд, урт хугацаанд хангах, санхүүгийн зах зээлийг хөгжүүлэхэд иргэдийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх асуудал чухал, ач холбогдолтой гэж үзэн бодлогодоо олон нийтийн санхүүгийн боловсролыг онцгойлон анхаарах болсон. Яагаад гэвэл иргэдийн санхүүгийн мэдлэг дээшилснээр санхүүгийн сахилга бат сайжирна. Санхүүгийн зохистой шийдвэр гаргах чадвар дээшилж, урт хугацаатай хуримтлал болон санхүүгийн хөрөнгө оруулалт нэмэгдэнэ. Санхүү, банкны системд итгэх итгэл дээшилнэ. Цаашлаад улсынхаа эдийн засгийн урт хугацааны тогтвортой өсөлт хөгжилд бодитой хувь нэмэр үзүүлнэ гэж тодорхойлсон. Тийм ч учраас улс орон хөгжих суурь бол иргэдийн нь сайн эзэмшсэн боловсрол дээр суурилдаг. Эдийн засгийн өсөлт тогтвортой байх нь иргэдийн санхүүгийн зөв хандлага, дадал хэвшилтэй асар чухал нөлөөтэй.

Төв банк яагаад олон нийтийн санхүүгийн боловсролд анхаардаг вэ?

Яагаад вэ гэдэгт хариулт өгөхийн тулд жишээ татъя. Бид нийтийн тээвэрт сууж, төлбөр төлөхдөө цэнэглэдэг карт ашигладаг болсон. Цалингаа авахдаа ихэнх нь бэлнээр бус банкны дансаар дамжуулж авч байгаа. Тэрчлэн дийлэнх нь харилцах эсвэл хадгаламжийн данстай, төлбөрийн янз бүрийн хэлбэрийн шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг авч байна. Ялангуяа, сүүлийн жилүүдэд банк, санхүүгийн салбарын өсөлт эрчимжиж, хүн амын дунд банкны харилцах данс, хадгаламж зээлийн үйлчилгээ гэх мэт санхүүгийн энгийн хялбар бүтээгдэхүүн хэрэглэх нь эрс нэмэгдсэн. Хэдий тийм боловч иргэдийн дунд санхүүгийн мэдлэг, санхүүгийн бүтээгдэхүүний тухай ойлголт дутмагаас яг хэрэгцээндээ тохирсон бүтээгдэхүүн сонгож чадахгүй байх, улмаар санхүүгийн шийдвэр гаргахдаа тооцоололгүй хандсанаас хүндрэл бэрхшээлтэй тулгарах зэрэг асуудал гарсаар л байна. Энэ нь тухайн өрх гэрийн санхүүгийн байдлаас гадна урт хугацаанд санхүү, эдийн засгийн системийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлдөг.

Иймээс санхүүгийн системийн тогтвортой байдлыг хангаж, санхүүгийн сахилга батыг өндөржүүлэх, шударга өрсөлдөөнийг бэхжүүлэх зорилгоор санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хүртэж байгаа харилцагчдын эрх ашгийг хамгаалах, санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх шаардлага бий болж байна. Мэдээж, хүн бүр л мөнгө, санхүүтэй холбоотой шийдвэрийг өдөр тутам гаргаж, тэдгээр шийдвэрийн үр дүнд эдийн засаг бүхэлдээ бүрэлдэн тогтож байна. Тэгэхээр, иргэдийн санхүүгийн мэдлэг сайжирснаар илүү оновчтой шийдвэр гаргах боломж нь нэмэгдэж, улмаар эдийн засаг маань тогтвортой байхад нөлөөлнө гэсэн үг. Түүнчлэн, Төв банкнаас хэрэгжүүлж буй бодлогыг сайн ойлгодог байх нь эргээд мөнгөний бодлогын хэрэгжилт, үр дүнтэй байдалд эергээр нөлөөлнө. Тийм ч учраас дэлхийд тэргүүлдэг төв банкууд санхүүгийн боловсролын тусгайлсан хөтөлбөр хэрэгжүүлдэг. Манай улсын хувьд ч мөн ялгаагүй 2016 оноос “Олон нийтийн санхүү, эдийн засгийн боловсролыг дэмжих үндэсний хөтөлбөр”-ийг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж байна.

Ялангуяа, манайх шиг шилжилтийн үе дээрээ явж байгаа улсад олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлнэ гэдэг тийм ч богино хугацаанд бүтэх асуудал биш байх гэж бодож байна?

Тийм ээ. Азийн санхүүгийн хямралаас сургамж авч, 2000 оноос эхлэн Япон, Голланд, Шинэ Зеланд, Сингапур, Их Британи болон АНУ зэрэг өндөр хөгжилтэй орнууд санхүүгийн боловсролыг бодлогын хэмжээнд анхаарч хэрэгжүүлдэг. Ганц эдгээр улс орнууд ч биш олон орон тэдний туршлагыг нэвтрүүлж эхэлж байна. 2011 оны байдлаар 26 орон олон нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх шатандаа явж байсан бол 2017 онд 65 болж өссөн. Санхүүгийн мэдлэг олгох бодлого боловсруулахдаа улс орнууд дэлхийн хөгжлийн чиг хандлага, олон улсын туршлага, өөрийн орны онцлог байдал, хүн амын санхүүгийн мэдлэгийн түвшинг харгалзан үзэж хөтөлбөрийнхөө чиглэл, зорилго, үйл ажиллагааны төлөвлөгөө зэргийг тодорхойлдог. Өөрийн улс орны онцлогт тохирсон агуулгатай хөтөлбөрүүд амжилтад хүрч, харин тэгж

чадаагүй бол үр дүн багатай байгаа нь харагдаж байгаа. Зарим улс орон анхан шатны стратегиа боловсруулж дараагийн шатны алхмаа тавьж улам боловсронгуй болгож байх жишээтэй. Ер нь төрийн байгууллагууд хоорондын бодлогын уялдаа бат сайн байж нэгдсэн үр дүнд хүрнэ. Нэг нь идэвхтэй зүтгээд нөгөө нь хайнга, хөшүүн, хойргодуу байгаад бас хэсэг хэд нь огт үгүйсгээд гэдийгээд суугаад байвал энэ ажил үр дүнд хүрэхгүй. Эцсийн үр дүн нь нийт эдийн засаг тогтвортой байж хүн бүрийг эдийн засгийн эрх чөлөөнд хүргэх суурь дадал хандлагыг төлөвшүүлэхэд зорьж байгаа учраас том зургаараа бол улс орны хөгжилд маш чухал хөтөлбөр байгаа юм.

Олон улсын байгууллагуудтай мэдээж хамтран ажиллаж, харилцан туршлага солилцдог байх. Санхүүгийн боловсролыг олгож байгаа хэлбэр, агуулгын хувьд ижил төстэй болон ялгаатай тал нь юу байдаг вэ?

Дээр хэлсэнчлэн ихэвчлэн тухайн улсынхаа онцлогтой уялдсан байдаг л даа. Жишээлбэл, БНСУ гэхэд л санхүүгийн боловсролыг телевизийн олон ангит киногоор дамжуулан түгээх жишээтэй. Англид богино хэмжээний видео хичээл г.м янз бүрийн арга хэлбэрээр, насны бүлэг бүрт чиглэсэн олон сонирхолтой туршлагыг нэвтрүүлсэн байдаг. Олон улсын санхүүгийн байгууллагуудаас өгдөг хамгийн чухал ач холбогдолтой зөвлөмжид санхүүгийн боловсролыг системтэйгээр түгээхийг онцолсон байдаг. Үүний дагуу сургуулийн хөтөлбөр, их дээд сургуулийн сургалтын хөтөлбөр мөн хөдөлмөр, нийгмийн хамгааллын болон иргэдийн насан туршийн боловсролын хөтөлбөрүүдээр байнга тогтмол түгээхийг санал болгодог. Монгол Улсын хувьд санхүүгийн боловсрол олгох чиглэлээр Эдийн засгийн хамтын ажиллагаа хөгжлийн байгууллага /OECD/-ийн INFE/ олон улсын санхүүгийн боловсролын сүлжээний байнгын гишүүнээр 2017 онд элсэн орсон. Мөн Дэлхийн банк, ХБНГУ-ын Хадгаламжийн банкны олон улсын сан, Child&Youth finance international-байгууллагатай нягт хамтран ажиллаж байна.

Эцсийн үр дүн нь нийт эдийн засаг тогтвортой байж хүн бүрийг эдийн засгийн эрх чөлөөнд хүргэх суурь дадал хандлагыг л төлөвшүүлэхэд зорьж байгаа учраас том зургаараа бол улс орны хөгжилд маш чухал хөтөлбөр байгаа юм.

Энэ бодлогыг хэрэгжүүлэхэд цаг хугацаанаас гадна төрийн болон төрийн бус байгууллага хоорондын хамтын ажиллагаа хэр уялдаа холбоотой байна вэ?

Мэдээж, бидний зүгээс санхүүгийн боловсролыг нийгмийн хариуцлага, санхүү эдийн засгийн тогтвортой өсөлт, ядуурал, санхүүгийн залилан, гэмт хэрэгтэй тэмцэх арга хэмжээ, цаашилбал ирээдүйн хөгжлийн олон гарц байгаагийн хамгийн зөв шийдэл. Тиймээс төр засаг, санхүүгийн бодлого тодорхойлогчид, боловсролын байгууллагууд, төрийн бус байгууллагууд, ажил олгогчид, иргэд гээд тал бүрээсээ хамтдаа зүтгэж, улс орныхоо хөгжилд нэмэр болох хамтын ажиллагаа гэж хардаг. Хамтарч байж үр дүнд хүрнэ. Бодлогыг хэрэгжүүлэхэд оролцогч талууд санхүүгийн боловсролыг дээшлүүлэх, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, санхүүгийн хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэхэд бодлого боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагааг санхүүжүүлэх, ивээн тэтгэх, судалгаа, шинжилгээ хийх болон техникийн туслалцаа үзүүлэх, сургалт зохион байгуулах, чадавхыг бэхжүүлэх талаар хамтарч ажиллах нь чухал. Мөн хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт, үнэлгээг хийхэд хамтарч ажиллах, нөөц бололцоо, мэдээ, мэдээллээ хуваалцах, бусад байгууллагыг үйл ажиллагаандаа татан оролцуулах зэрэг ажлын хүрээнд хамтран ажиллах нь чухал л даа.

Олон нийтийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх ажлыг хэрэгжүүлэхэд ямар хүндрэл, бэрхшээл гарч байна вэ?

Санхүүгийн боловсролыг системтэй түгээхэд хамгийн гол үүрэг гүйцэтгэх субъект нь төр юм. Төрийн тогтворгүй байдал, бодлогын залгамж, үргэлжлэл алдагдах нь бодлого хэрэгжүүлэхэд цаг хугацааны хувьд бэрхшээл үүсгэдэг. Нэгэнт батлагдсан бодлогыг залгамжилж тогтвортой үргэлжлүүлэх нэн шаардлага бий. Ном сурах бичиг, багш, багшийн гарын авлага нь бэлэн болсон байгаа хэдий ч ахлах ангийнханд заах

хичээлийн хуваарь өнөөг хүртэл тодорхойгүй хэвээр байгаа.

Цаашид иргэд, олон нийтийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх асуудалд Төв банкаас ямар байр суурьтай байна вэ?

Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх бодлогын хувьд “Монгол Улсын санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-т иргэдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх, улмаар санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэл тусгагдсан. Мөн Төрөөс мөнгөний бодлогын талаар 2019 онд баримтлах үндсэн чиглэлийн хүрээнд Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх ажлыг эрчимжүүлж, хамрах хүрээг өргөжүүлэхээр зорьж байна. Үүний тулд, сурагчдад санхүүгийн суурь мэдлэг олгох хичээлийг заавал судлах хичээлийн хөтөлбөрт засгийн газартай хамтран хэрэгжүүлэхээр зорьж байна. Их дээд сургуульд санхүүгийн мэдлэгийн цар хүрээг нэмэгдүүлэх шаардлага бий. Хөдөө, орон нутгийн иргэдэд санхүүгийн мэдлэг тогтмол олгох сургалтын суваг, сүлжээг бий болгоно. Санхүүгийн мэдлэг олгох үйл ажиллагааг банк санхүүгийн байгууллага, төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран хэрэгжүүлэх үйл ажиллагааг өргөжүүлэх хэрэгтэй байгаа. Бичил, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд чиглэсэн санхүүгийн боловсрол олгох тэргүүлэх чиглэлийн суурь нөхцөлийг судална. Цахим хуудас, олон нийтийн мэдээллийн хэрэгсэлд суурилсан санхүүгийн мэдлэг олгох бүтээгдэхүүний төрлийг нэмэгдүүлж, хүртээмжийг нь дээшлүүлэх гэх мэтчилэн ажлууд төлөвлөгдсөн.


Ярилцсанд баярлалаа.



Алтны шинж чанар



Алт нь дэлхий дээр 200 сая орчим жилийн өмнө солхрын бороо болон маш өндөр температурын үр дүнд үүссэн.



Алтыг 6000 жилийн өмнөөс барад, тэвээр худалдаж авах мөнгөн тэмдэгтээр ашиглаж эхэлсэн.



Эдийн засаг болон соёлын хувьд алт нь хүч чадал, гоо зүй, амжилтын нлэрхийлэл болдог.



Алт нь байгаль дээр ихэвчлэн бичил хэмжээтэй оршдог.

Алтны хэрэглээ



Дэлхийд жилд 2,500 орчим тонн алт олборлож байна



51%
Үнэт здлэл



18%
Хөрөнгө оруулалт



17%
Төв банк - зоос, гулдмай



12%
Технологи

Эх сурвалж: World gold council

Монголбанкны алт худалдан авалт



Монголбанкны бодлогын талаарх мэдээллийг дарууц хөнгөлөөр авна уу.



Аливаа улс орны гадаад валютын нөөц нь тухайн улсынхаа үндэсний аюулгүй байдлын баталгаа болж байдгийн хувьд нөөц бүрдүүлэлт бол бодлогын чухал стратеги юм. Уг нөөцийг бүрдүүлэхэд алт онцгой үүрэг гүйцэтгэдэг бөгөөд хатуу валют гэж үздэг. Үнэ цэнэтэй уг металын эдийн засаг дахь ач холбогдлын талаар дэлхийн нэр хүнд бүхий мэргэжилтнүүд юу гэж дүгнэсэн байдгийг сонирхууллаа.



Европын Төв банкны Ерөнхийлөгч Марио Драги:

“Алт нь улс орнууд, Төв банкны хувьд аюулгүй байдлын нөөц, баталгаа болдог учраас арилжаалж худалдаалахыг би ухаалаг алхам гэж үзэж байгаагүй. Долларын ханш хэлбэлзэх үед алт нь бусад улс оронд үнийн хамгаалалтыг бий болгох боломжтой тул эрсдэлээ хувааж байршуулах гэх мэт шалтгаанаар гадаад валютын нөөцөд алтыг байршуулдаг. Гадаад валютын нөөцийн бодлогод тусгаснаас алтны хэмжээ давах үед болон бусад шалтгааны улмаас зарим Төв банк алтыг худалдаалж ирсэн.”



ОХУ-ын Төв банкны тэргүүн Эльвира Набиуллина:

“Гадаад валютын нөөцийг төрөлжүүлэх бодлогын хүрээнд бид өнгөрсөн жилүүдэд болон энэ жил алт худалдаж авсаар ирсэн. Манай алт үйлдвэрлэлийн салбарын хөгжил өндөр бөгөөд гадагш алт нийлүүлэх бүрэн боломжтой. Тиймээс ч бид төрөлжүүлэх бодлогын дагуу алтыг зарж байгаа. Орос Улс алтны нөөц өндөртэй, шокийг саармагжуулах хэрэгслүүдтэй. Хөвөгч ханшийн дэглэмийг нэвтрүүлсэн нь тэдгээр шокийг шингээх боломжийг бүрдүүлсэн.”



Хятадын Ардын банкны тэргүүн асан Жоу Сяочуань:

Төв банкуудын гадаад валютын нөөц бүрдэлтэд алт томоохон байр суурь эзэлсэн хэвээр байгаа. Алт, гадаад валют, ОУВС-ийн зээлжих тусгай эрх зэрэг нь эрсдэлээс хамгаалах зорилготой хэрэгслүүд. БНХАУ-ын алтны зах зээлийн үүсэл, хөгжил нь Хятад Улсын бусад санхүүгийн зах зээл, тэр дундаа гадаад валют, хөрөнгийн, даатгалын захын хөгжлийг дэмжиж өгч байгаа. Бүрэн ажиллагаатай санхүүгийн зах зээлийн тогтолцоо нь өөрөө БНХАУ-ын макро эдийн засагт нөлөөлөх микро орчны тогтвортой бөгөөд үр ашигтай байдлыг бий болгоно. Тиймээс БНХАУ нь алтны арилжааг аюулгүй бөгөөд үр ашигтай явуулахын тулд гурван чиглэлээр өөрчлөлт хийж байгаа. Тэдгээрийг дурдвал, таваар хэлбэрийн захыг санхүүгийн хэлбэрт шилжүүлэх, спот арилжааг фьючерсийн арилжаанд өөрчлөн хөгжүүлэх, дотоодын зах зээлийг олон улсын зах зээлтэй холбох юм.



АНУ-ын тэрбумтан Бриджуотер ассошиет үндэстэн дамнасан хөрөнгө оруулалтын компанийг үүсгэн байгуулагч Реймонд Далио:

“Алт бол өөрөө валют юм. Хэрэв чи алтанд хөрөнгө оруулаагүй нэгэн бол түүх мэддэггүй эсвэл эдийн засаг ойлгодоггүй гэсэн үг.”



Алдарт хөрөнгө оруулагч Уоррен Баффет:

“Эрсдэлд мэдрэг, хөрөнгө оруулалтын хэрэгслүүдээс эмээдэг хөрөнгө оруулагчдын хамгийн дуртай хөрөнгө оруулалтын хэрэгсэл бол алт юм. Ялангуяа, валютад хөрөнгө оруулахаас, арилжаанд оролцохоос болгоомжилдог хүмүүс алтыг их таалдаг. Гэхдээ эрсдэл, өгөөж хоёр эерэг хамааралтай гэдгийг санах хэрэгтэй. Алт нь хоёр сул талтай. Алтны бодит хэрэглээ хязгаарлагдмал ба үржүүлэгч нөлөөгүй.”



Канадын эдийн засагч, алтны үнийн шинжээч

Мартин Муренбилд:
“Дэлхийн худалдааны дайн, Европ дахь улс төрийн тодорхойгүй байдал, Умард Солонгостой дахин дахин хийж байгаа хэлэлцээрүүд нь урт хугацаанд алтыг эрсдэлийг даатгах хэрэгсэл болгож байна. “Муренбилд энд Ко” компаниас гаргасан судалгаанаас алтны ханш унц тутамд 2018 онд дунджаар 1,313 ам.доллар байх ба 2018 оны эцэст 1,316 ам.долларт, 2019 оны дундаж 1,341 ам.долларт тус тус хүрэхийг тэмдэглэсэн.”


АЛТНЫ ҮНИЙН ПРОГНОЗ

	2018 ОНЫ ДУНДАЖ	2018 ОНЫ СҮҮЛ	2019 ОНЫ ДУНДАЖ
А ХУВИЛБАР: P=25% БУЮУ ХАМГИЙН МУУ ТОХИОЛДОЛ	\$ 1260	\$ 1178	\$ 1124
Б ХУВИЛБАР: P=60% БУЮУ МЕДИАН	\$ 1313	\$ 1316	\$ 1341
В ХУВИЛБАР: P=15% БУЮУ ХАМГИЙН САЙН ТОХИОЛДОЛ	\$ 1344	\$ 1408	\$ 1497
ЖИГНЭСЭН ДУНДАЖ	\$ 1301	\$ 1298	\$ 1340
ТРАМПЫН ХУДАЛДАА, ГЕОПОЛИТИКИЙН ХҮЧИН ЗҮЙЛ	\$ 5	\$ 5	\$ 5
ЭЦСИЙН ДУНДАЖ	\$ 1296	\$ 1293	\$ 1355

Эх сурвалж: Murenbeeld & Co.

2018 оны 7-р
сарын 21-ний
байдлаар

ЭРДЭС БАЯАГИЙН САЛБАРТ НЭГДСЭН ЦАХИМ БҮРТГЭЛИЙГ УЛС ӨРНҮҮД ӨРГӨН АШИГЛАЖ БАЙНА



Эрдэнэсийн сангийн
Ахлах эдийн засагч
Д.АЛТАНСҮХ

Алтны нийлүүлэлтийн сүлжээний талаар туршлага судлахаар манай улсаас УИХ-ын гишүүн С. Бямбацогтоор ахлуулсан баг Колумб, Эквадор улсад ажилласан юм. Багийн бүрэлдэхүүнд УИХ-ын гишүүд, УУХҮЯ, АМГТГ, Монголбанк, Үнэт металлын сорьцын хяналтын газар, Баянхонгор аймгийн Засаг дарга, Монголын бичил уурхайн нэгдсэн дээвэр холбооны төлөөлөл болон төслийн ажилтнууд багтаж байлаа. Бидний туршлага судлах ажил Бүгд Найрамдах Колумб улсаас эхэлж, тус улсын Уул уурхай эрчим хүчний яам, Уул уурхайн үндэсний агентлаг, Худалдаа үйлдвэр, аялал жуулчлалын яам, Уул уурхайн үндэсний ассоциаци болон алт экспортлогч Три Карго компанийнхантай уулзалт хийсэн юм. Мөн төлөөлөгчид Богота хотод байрладаг алтны цэвэршүүлэх үйлдвэрийн үйл ажиллагаатай танилцсан нь бидний үйл ажиллагаанд нэн чухал байв.

КОЛУМБ УЛС НЭГДСЭН ЦАХИМ БҮРТГЭЛЭЭР АЛТНЫ ХУДАЛДААГАА АЛБАЗУУЛЖЭЭ

Колумб Улс нь жилд ойролцоогоор 40 тонн алт олборлодог бөгөөд алтны худалдааны чөлөөт системтэй буюу хувийн хэвшил дангаараа оролцдог онцлогтой юм байна. Тодруулбал, алт сорьцлох, цэвэршүүлэх, худалдан авах, экспортлох үйл ажиллагааг хувийн хэвшил гүйцэтгэдэг тул манайхаас ялгаатай аж. Уул уурхайн үндэсний агентлагаас нь иргэн аж ахуйн нэгжид алт худалдан авах, экспортлох эрхийг, олгож, нэгдсэн цахим бүртгэлийн системийг /платформ/ ажиллуулснаар алтны худалдаанд ил тод байдлыг хангахад тодорхой алхам хийжээ.

Колумб улсын Уул уурхай эрчим хүчний яамны дэд сайд Карлос Кантетай уулзахад тэрээр Колумб Улс эрдэс баялгийн салбарыг хөгжүүлэхэд маш олон арга хэмжээ авч хэрэгжүүлсэн тухай танилцуулсан юм. Ялангуяа, ололт амжилт, алдаа оноон дээрээ тулгуурлаж бичил уурхайн салбарыг албажуулахад бусад орны туршлагаас суралцаж нэвтрүүлсэн нь сайн үр дүнд хүрсэн байна. Ингэснээр алтны нийлүүлэлтийн сүлжээг албажуулах, бүртгэлжүүлэх, ил тод болгох талаар төрийн зүгээс нэлээдгүй арга хэмжээ авч байгаагийн нэг нь цахим бүртгэлийн платформыг ажиллуулдаг болсон явдал аж.



Колумбын Уул уурхайн яамны дэд сайд Карлос Кантентийн хамт

Цахим бүртгэлийн платформыг ажиллуулснаар хууль бус алтыг сүлжээнд орохоос сэргийлэх, гарал үүслийг ил тод болгоход чухал ач холбогдолтой юм.

Колумбын улсын эрдэс баялгийн салбар нь 2021 он гэхэд алтны гарал үүслийг бүх шатанд ил тод болгохоор ажиллаж байна. Энэ нь Европын Холбооны улсын эрдэс баялгийн гарал үүсэл, ил тод байдлыг хангах хууль 2021 оноос хүчин төгөлдөр болохтой холбоотой юм.

Цахим бүртгэлийн систем нь уул уурхайн салбарт ажиллаж байгаа бичил уурхайн байгууллага, иргэдээ ангилан бүртгүүлжүүлдэг. Тодруулбал, албан, албан бус, хууль бус гэж ангилсан байна. Албан гэдэгт нь албан бүртгэлтэй том, дунд, жижиг уурхай, албан бусд амьжиргаагаа залгуулах зорилгоор ямар нэгэн техник тоног төхөөрөмж ашиглахгүйгээр гар аргаар алт олборлож байгаа, хууль дүрэм, мэдлэг мэдээллээс хол, нутгийн иргэдийг хамааруулдаг байна. Эдгээр иргэдийг бүртгэлжүүлэн албажуулж жижиг уул уурхайн ангилалд хамруулснаар төрөл бүрийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээг төрөөс нь үзүүлдэг байна. Харин хууль бус гэдэгт нь техник ашигладаг, зориуд санаатайгаар хууль бус үйл ажиллагаа явуулдаг бүлгийг бүртгэдэг бөгөөд ихэвчлэн зохион байгуулалттай гэмт хэргийн болон зэвсэгт бүлэглэлтэй холбоотой хүмүүс байдаг. Энэ бүлэгтэй мэдээж, хууль бус уул уурхай эрхлэхийг нь хориглож, хуулийн дагуу цогц арга хэмжээ авч ажилладаг.

Колумбын албан ёсны тусгай зөвшөөрөл бүхий анхны хувийн алт цэвэршүүлэгч байгууллагуудын нэг болох Аллой компанитай танилцлаа. Эднийх алт цэвэршүүлэх, улмаар дотоодын зах зээлд нийлүүлэх чиглэлээр 30 жил ажилласан туршлагатай юм байна.

Аллой нь дунд хэмжээний үйлдвэрлэл явуулдаг алт цэвэршүүлэх байгууламж бөгөөд жилд 10-12 тонн алт цэвэршүүлэх хүчин чадалтай ба цэвэршүүлсэн алтаа дотоодын алт мөнгөн эдлэлийн зах зээлд зориулан худалдан борлуулдаг байна.

Цэвэршүүлсэн алтны бүртгэлийг нарийн чанд

хөтөлдөг дотоод хяналтын хатуу системтэй. Алтыг зөвхөн албан ёсны алт нийлүүлэгчдээс худалдан авдаг байна. Аллой компани нь Колумбын Худалдаа, аялал жуулчлалын яамтай хамтран ажиллаж алт мөнгөн эдлэлийн кластерийн төсөлд оролцдог. Мөн Олон улсын Шударга олборлолтын сертификат бүхий алтыг цэвэршүүлэхэд бичил уурхайн байгууллагуудтай хамтран ажилладаг байна. Алт сорьцох үйл ажиллагаа нь олон улсын стандартын дагуу явагддаг нь Монгол Улсад мөрдөж байгаа аргачлалтай адил байв.

Колумб Улсад алтны экспортыг хувийн хэвшлүүд гүйцэтгэдэг нь Монгол Улсаас ялгаатай тухай тэмдэглэлийнхээ эхэнд дурдсан. Уул уурхайн үндэсний агентлагийн цахим платформд бүртгэлтэй, Худалдаа, аялал жуулчлалын яамнаасаа зөвшөөрөл авсан 4-5 алтны худалдаа эрхлэгч компаниуд алт экспортлох үйл ажиллагаа эрхэлж байна. Мөн гааль тээвэр зуучийн үйл ажиллагаа эрхэлдэг хэд хэдэн компани үйл ажиллагаа явуулдаг байна.

ЭКВАДОР АЛТНЫ НӨӨЦИЙНХӨӨ 60 ХУВИЙГ ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛД ЗАРЦУУЛДАГ

Эквадор Улсын алтны худалдааны орчин нь Төв банк алтыг худалдан авч улсынхаа валютын нөөцийг бүрдүүлэхээр ажиллаж байгаагаараа Монгол Улстай төстэй юм. Харин 2002 оноос хойш хувийн хэвшлүүдэд орон нутагт алт худалдан авах зөвшөөрлийг Төв банкнаас олгосноороо онцлогтой аж. Энэ нь алтны салбарыг албажуулж, ил тод байдлыг хангахад чухал үүрэгтэй юм гэж тус улсын албаны төлөөлөл онцолж байлаа. Алтны нийлүүлэлтийг нэмэгдүүлэхийн тулд 2018 оноос эхлэн бичил уурхайчдаас алтыг шууд худалдан авахаар ажиллаж эхэлжээ. Мөн орон нутагт алт худалдан авах цэгүүдийг ажиллуулахаар төлөвлөсөн байна. Уул уурхайн яам, агентлаг, татварын болон цагдаагийн байгууллагуудтай хамтран, мэдээлэл солилцож хаанаас олборлосон алтыг хаана, хэн арилжаалж байгаад хяналт тавьж ажилладаг. Мөн мэдээллийн сангаас


татвар төлсөн эсэхийг шалгаж, төлөөгүй тохиолдолд гаалиас буцаадаг тогтолцоотой юм байна. Алтны сорьцлолт, цэвэршүүлэх явцад усан болон хуурай жингийн аргыг ашигладаг. 2017 онд Эквадорын Төв банк нэг тонн гаруй алт худалдан авч нөөцөлсөн бөгөөд одоогоор алтаа нөөцлөх бодлого баримталж экспортод гаргаагүй байна.

Эквадор Улсын Уул уурхайн яам нь тус улсын уул уурхайн бодлогыг боловсруулж зохицуулах, хянаж үнэлэх үүрэгтэй ажилладаг. Үндэсний хэмжээний болоод уул уурхай, бичил уурхайн асуудал хариуцсан үндэсний хоёр ажлын алба, бүсийн таван дэд алба яамны харьяанд нь ажилладаг. Эквадорын Уул уурхайн яам эдийн засгийн нээлттэй бодлого хэрэгжүүлж, хөрөнгө оруулалт татах, том уул уурхайгаа хөгжүүлэх талаар стратеги боловсруулан ажиллаж байна. Ашигт малтмал ашигласны нөөцийн төлбөрийн 60%-ийг орон нутгийн хөгжлийн үйл ажиллагаанд зарцуулахаар үлдээдэг байна. Түүнчлэн уул уурхайн том компаниудыг Ашигт малтмалын нөөц ташигласны татвар/АМНАТ/-аа урьдчилан төлсөн тохиолдолд тухайн төлбөрийг тухайн орон нутгийн нийгмийн болон дэд бүтцийн хөрөнгө оруулалтад ашигладаг нь уул уурхайн үр ашгийг орон нутгийн иргэд түрүүлэн хүртэх боломжоор хангагддаг байна.

Уул уурхайн яамны харьяа Геологи, уул уурхай, металлургийн судалгааны үндэсний хүрээлэн нь тус улсын геологи, уул уурхай, металлургийн холбогдолтой мэдээллийг бүрдүүлэх, системчлэх болон зохицуулах үүрэгтэй гэнэ. Тус хүрээлэн нь бичил уурхайн үйл ажиллагааг албажуулахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Бичил уурхай эрхлэгчид тус хүрээлэнгээс зохион байгуулдаг хөдөлмөр аюулгүй ажиллагаа, техникийн болон байгаль орчны сургалтуудад заавал хамрагдах ёстой бөгөөд одоогийн байдлаар нийт 5,000 орчим иргэнийг сургаад байна.

Эквадор Улсын Техникийн их сургуулийн харьяа Уул уурхайн инноваци ба хөгжлийн төв нь уул уурхайн гол бүсийн нэг Лоха хотод байрладаг юм. Энэ төвийн зорилго нь орон нутгийн иргэдийг сургалтад хамруулж тэдний чадвар, чадамжийг дээшлүүлэх, мэдлэг түгээх замаар уул уурхайн салбарт ажил хөдөлмөр эрхлэх, ажлын байр бий болгох боломжийг дээшлүүлэхэд оршдог. Тус төвөөс мөнгөн усыг алт баяжуулах аргачлалаас халж өөр арга замыг иргэдэд зааж сургахад анхаарч ажиллаж байна.

Намбиха бичил уурхайн төв нь Эквадорын Зүүн өмнөд бүс нутагт Тунантзага ууланд байрладаг 20,000 гаруй уурхайчинтай хотхон юм. Намбиха дахь уул уурхайн үйл ажиллагаа 1982 онд эхэлсэн бөгөөд албан бус олборлогчид нь анжис, түрдэг тэрэг, тамга тээрэм зэрэг энгийн суурьтай тоног төхөөрөмжөөр үйл ажиллагаа явуулж эхэлжээ. Энэ хотхонд байрлаж буй бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчид бүлэг нөхөрлөлийн зохион байгуулалтад орж байгаль орчин, нийгэмдээ илүү хариуцлагатай үйл ажиллагаа явуулахаар нэгдэж байгаа сайн жишээ байна.



Эдгээр улс оронд авч хэрэгжүүлж буй бодлого туршлагаас үзэхэд алтны нийлүүлэлтийн сүлжээ гэдэгт олборлох үйл ажиллагаанаас эхлээд эцсийн хэрэглэгч хүртэлх хоорондоо холбоо хамаарал бүхий бүх үйл ажиллагааг хамааруулсны дээр бичил уурхайн албажуулалт үүний салшгүй нэг хэсэг нь болжээ. Албажуулалтын эрх зүйн орчны хувьд манай улс эдгээр улс орноос харьцангуй дэвшилтэй ажиллаж байгаа хэдий ч хууль бус уул уурхайн үйл ажиллагаа байсаар байгаа нь албажуулах ажлыг эрчимжүүлэх шаардлагатайг харуулж байна.

Манай улсын хувьд албажуулалтын үйл ажиллагаанд зарцуулах хөрөнгө, хүний нөөцийг нэмэгдүүлэх шаардлага бий. Уул уурхайн оролцогчдын ангилал, тодорхойлолтыг эргэн харж цэгцлэх нь хууль, журмын дагуу үйл ажиллагаа явуулж байгаа албан ёсны бичил уурхайчдыг хууль бусаас ялгах боломжийг бий болгох юм.

2017 онд Монгол Улс 20 тонн алт худалдан авсны 64% нь хувь иргэдээс худалдан авсан. Энэ нь 12.8 тонн алтны хэдэн хувь нь бичил уурхайгаар олборлосон, хэдэн хувь нь татвараас зугтаасан аж ахуйн нэгжийн алт болохыг тодорхойлохын тулд бүртгэлийг нэн даруй сайжруулах арга замыг тодорхойлохоос гадна шаардлагатай алтны нийлүүлэлтийг багасгахгүйгээр гарал үүсэл, ил тод байдлыг хангахад анхаарч татварын оновчтой тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай байгаа билээ. Европын улсуудад нийлүүлэх алт, алтан эдлэлийн гарал үүсэл, ил тод байдлын тухай хууль 2021 оноос хүчин төгөлдөр болох тул эдгээр бодлогын арга хэмжээнүүд авч хэрэгжүүлэх тухай дүгнэлт гарч байгаа билээ.

Тэрчлэн алтны олборлолт ихтэй орон нутаг сорьцлох үйлчилгээний төвүүдийг байгуулах нь зүйтэй болохыг дээрх улсуудын туршлага харуулж байна. Алт худалдан авалтын төвлөрлийг сааруулж орон нутагт сорьцлох, худалдан авах үйл ажиллагааг нээлтэй болгох нь алтны нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, гарал үүслийг тодорхой болгоход чухал алхам болох юм. Үүний зэрэгцээ холбогдох төрийн байгууллагаас (Монголбанк, АМГТГ) алтны худалдааны сүлжээнд оролцогч бүх талуудыг бүртгэх, албажуулах алхмыг хийх хэрэгтэй. Одоо байгууллага, орон нутаг тус бүрд салангид байгаа бүртгэлүүдийг нэгтгэж нэгдсэн том

онлайн бүртгэл, мэдээллийн системийг бий болгосноор зөвхөн алт төдийгүй бусад эрдэс баялгийн олборлолт, тээвэрлэлт, худалдааны үйл ажиллагаанд оролцогчдын мэдээллийг холбогдох байгууллагууд нэг дороос авах боломж бүрдэж улмаар хяналтыг сайжруулахад чухал алхам болно. Монгол Улсаас хууль бусаар их хэмжээний алт хил давж буй тухай албан бус мэдээлэл байдаг бөгөөд энэхүү гадагшаа урсах хууль бус хар зах зээлийг хаахад хууль хяналтын байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах, хил, гаалийн хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

Дэлхий нийтээр олборлох үйл ажиллагаанд химийн хорт бодис, ялангуяа мөнгөн усыг хэрэглэхийг хориглож байна. Колумб, Эквадор, Монгол Улс ч энэ эгнээнд нэгдэн орж Минаматагийн конвенцийг хэрэгжүүлж байгаа билээ. Харин байгаль орчин, хүний эрүүл мэндэд ээлтэй орлохуйц техник, технологийн шийдлийг төрөөс бодлогоор чиглүүлж өгөх хэрэгтэй гэдэг нь 2 орны туршлагаас харагдаж байна. Ингээгүй тохиолдолд химийн хорт бодисын хэрэглээ улам нууц, аюултай түвшинд шилжинэ гэдэг нь манай улсын өмнөх туршлагаас харагдаж байгаа билээ. Швейцарийн хөгжлийн агентлагийн Тогтвортой бичил уурхай төслийн санаачилгаар мөнгөн усгүй, хүндийн хүчний аргаар алтыг ялган авах технологийг Монголд нутагшуулж байгаа нь сайшаалтай.

Байгаль орчин, хүний эрүүл мэндэд ээлтэй олон улсын санал санаачилга, стандартуудыг нэвтрүүлж, нутагшуулах, дэлгэрүүлэх нь цаашид Монгол Улсад хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх ач холбогдолтой. Цаашид энэ стандартын дагуу олборлосон алтны хэмжээг нэмэгдүүлэх нь хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэхэд түлхэц болох, олон улсын тавцан дах Монгол Улсын нэр хүнд өсөх, нөхөгддөггүй байгалийн баялгаа нэмүү өртөг шингэсэн үнээр худалдаалах боломжтой болох юм.

Колумб, Эквадор улс аль аль нь алтны сорьцлолт, худалдааг либералчлах бодлого явуулж байгаа нь төр өөрийн үүргээ шилжүүлж ачааллаа бууруулах, үндсэн чиг үүрэг болох хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх, хянах, татвар тооцож суутгахад голлон анхаарах ач холбогдолтой юм. Уул уурхайгаас орж байгаа орлогоо дэд бүтэц, бүтээн байгуулалт болон нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд түлхүү ашиглаж байна.

1955 ОНЫ МӨНГӨН ТЭМДЭГТ

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1954 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн тогтоолоор Монголын Худалдаа Аж Үйлдвэрийн банкны нэрийг “Улсын банк” болгон өөрчилжээ. Тиймээс 1955 онд кирилл үсгээр бичсэн бичвэртэй, нэрлэсэн үнэ, өнгөрөө ялгагдах 1, 3, 5, 10, 25, 50, 100-тын дэвсгэртэй шинэ мөнгөн тэмдэгтийг хэвлүүлсэн байна.

Нүүр тал: “Бүгд Найрамдах Монгол Ард Улс”, “Улсын банк”, “Банкны тэмдэгтүүд нь БНМАУ-ын, Улсын банкны үнэт металл, гадаадын валют, бараа ба бусад активаар батлагдана” гэсэн бичвэртэй. Түүнчлэн мөнгөн тэмдэгтийн нэрлэсэн үнэ, оныг доош цувруулан бичиж, баруун талд нь жанжин Д.Сүхбаатарын хөрөг, зүүн талд нь Монгол Улсын төрийн сүлдийг дүрсэлж, дөрвөн буланд нь нэрлэсэн үнийг араб тоогоор бичсэн. Серийн дугаарын хоёр үсэг, зургаан оронтой тооны дардсыг хар, улаан өнгөөр доод хэсэгт даржээ.

Ар тал: Төв хэсэгт дугуй хээг суурь болгон доош цувруулан он, нэрлэсэн үнэ, “Хэрэв банкны тэмдэгтүүдийг хуурамчаар үйлдвэл гэмт этгээдийг хууль ёсоор хариуцлагад татна.” гэсэн бичвэртэй. Уг бичвэрийн хоёр талд өлзий хээн дээр нэрлэсэн үнийг араб тоо, кирилл үсгээр, дөрвөн буланд араб тоогоор тус тус бичсэн.





НЭГ САЛБАРААС ХЭТ ХАМААРАЛТАЙ ЭДИЙН ЗАСАГ НЬ ТУХАЙН САЛБАР УНАЛТАД ОРОХОД ДАГАЖ УНАХ ТОМ ЭРСДЭЛТЭЙ

Аж үйлдвэржилтэд хөтлөх, гадаад зах зээлд өрсөлдөх чадвартай компаниудыг бий болгож, дэмжих шаардлагатай байдаг. Үүний тулд:

- Аж үйлдвэрлэлийг хөгжүүлэх (үйлдвэрлэгч, экспортлогч улс болох),
- Шударга өрсөлдөөнийг бий болгох, дэмжих,
- Олон улсын зах зээл дээр өрсөлдөх чадвартай компаниудыг бий болгоход макро түвшинд дэмжих,
- Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжихөд хөтлөх, таатай нөхцөл бий болгох,
- Уул уурхайн салбараас олсон орлогын тодорхой хувийг аж үйлдвэржилтэд хөтлөхөд зарцуулах,
- Аж үйлдвэржилтийг өндөр технологид суурилахад дэмжих зэрэг юм.

Монгол Улс 2 том гүрэн болох ОХУ болон БНХАУ-тай хиллэдэг, мөн тээвэрлэлтийн томоохон хэлбэрүүдийн нэг болох далайн тээвэрлэлт огт хөгжөөгүй нь далайд гарцгүйтэй холбоотой юм. Түүнчлэн Монгол Улсын экспортын бүтцэд уул

уурхайн түүхий эдийн экспорт хамгийн их буюу сүүлийн 3 жилийн дунджаар 90 орчим хувийг эзэлж байгаа нь бусад салбарын экспортын түвшинг илтгэж байна. Энэ нь манай улсын экспортын орлогыг мөн эдийн засгийг уул уурхайн бүтээгдэхүүний үнээс шууд хамааралтай болгож байна.

Нэг салбараас хэт хамааралтай эдийн засаг нь тухайн салбар уналтад ороход дагаж унах том эрсдэлтэй байдаг. Түүнчлэн Улаанбаатарын 8 зарчмын нэг болох “Байгалийн баялгаа оновчтой байдлаар эдийн засгийн эргэлтэд оруулах, баялгийн ерөөлд хүргэх, хүртээмжтэй өсөлтийг бий болгох” нь хангагдахгүй бол баялгийн хараал (Dutch disease) тусах аюултай. Энэ нь улс орны бэлэнчлэх сэтгэлгээг нэмэгдүүлж, авилгал хээл хахууль өргөжих орчинг бүрдүүлж “Засаглал, институцийг сайжруулж, чанарыг бэхжүүлэх, авилгалын эсрэг тууштай тэмцэх” зарчмыг хэрэгжихэд хүндрэлтэй болгох мөн уул уурхайн салбар хэт хөгжиж, боловсон хүчин нэг салбарт төвлөрөн, бусад салбарын хөгжлийг саармагжуулах зэрэг эрсдэлийг дагуулдаг байна.



Эх сурвалж: Монголбанк

Экспортыг төрөлжүүлэх нь манай улсын хувьд эергээр нөлөөлөхөөр байна. Цаашлаад аж үйлдвэржилтэд суурилсан дэлхийн зах зээлд өрсөлдөх чадвартай компаниудыг бий болгосноор уг компаниудыг дагасан жижиг дунд үйлдвэрүүд хөгжих нь ажилгүйдлийг бууруулах, эдийн засгийн өсөлтөд эергээр нөлөөлөх зэрэг тустай юм. Гэхдээ эдгээр компаниудыг бий болгож дэмжих эх үүсвэр нь зээл бус хөрөнгө оруулалт байх нь манай улсын хувьд илүү өгөөжтэй байх болно. Уул уурхайн бүтээгдэхүүний экспортын орлогоос тодорхой хувийг аж үйлдвэржилт болон бусад салбарт зарцуулж олон улсын хэмжээнд өрсөлдөх чадвартай компаниудыг бий болгох, цаашлаад бодлогын хүрээнд дэмжих нь эдийн засагт чухал ач холбогдолтой.

Олон улсын туршлагаас харвал хурдацтай хөгжиж буй экспортын салбар нь ялангуяа хөгжлийн эхний үе шатанд, эдийн засгийн өсөлтөд чухал хүчин нөлөө үзүүлж чаддаг. Хэрэв эдийн засаг экспортоо төрөлжүүлж, шинэ салбарт бүтээмжтэй ажлын байр бий болгож байгаа бол засгийн газар үүнийг дэмжихэд оролцож болох боловч дараах зүйлсийг анхаарч хэрэгжүүлэх шаардлагатай.

- Уул уурхайн салбарын төвлөрлийг саармагжуулж, бусад салбарыг зэрэг хөгжүүлэх бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх,
- Олон улсад өрсөлдөх чадвартай зүтгүүр компаниуд бий болгож тэдгээрийг дагасан жижиг дунд үйлдвэрлэл хөгжихөд дэмжлэг үзүүлэх, таатай нөхцөл болон шударга

өрсөлдөөнийг түүчээлэх,

- Эдгээр нөхцөл боломжуудыг хангах эх сурвалж нь зээл бус хөрөнгө оруулалт (Дэлхий ертөнц бүхэлдээ шинэ хөрөнгө оруулалтын төлөөх тулааны талбар болсон үед гадаадын шууд болон хувийн хөрөнгө оруулалтыг тууштай даллан дуудах, эдийн засгийн дархлааг хангах хэмжээнд гадаад валютын нөөцийг хуримтлуулах, өрийн дарамтад орохоос сэргийлэх зарчмууд)-ын хангаж байх мөн эдгээр компаниудын хөрөнгө нь зээл/хөрөнгө оруулагчдын өмч (капитал) – ын оновчтой хослолоос бүрдсэн, эрүүл байх нь чухал,
- Орчин үеийн өндөр технологид аж үйлдвэржилтийг суурилуулахад нь дэмжих бололцоог судлах, хэрэгжүүлэх,
- Засгийн газрын шийдвэл зохих асуудал нь байнгын бус учраас дэмжлэг нь түр зуурынх байх хэрэгтэй,
- Дэмжлэгийн үр дүнг байнга үнэлэх хэрэгтэй бөгөөд хэрэв хүсч байсан үр дүн гарахгүй тохиолдолд төр оролцоогоо зогсоох ёстой,
- Хэдийгээр эдгээр бодлого нь экспортын тухайн нэг салбарыг дэмжих хэдий ч ямар экспортыг дэмжих нь боломжит түвшинд ижил тэгш байх ёстой бөгөөд тухайн нэг салбарыг шууд сонгож оролцохоос илүүтэй хувийн салбарт байнгын боломж үлдээх шаардлагатай,
- Экспортыг дэмжих нь чухал хэдий ч өсөлтийн бусад чухал хүчин зүйл болох боловсрол, дэд бүтэц, цаг үеэ мэдэрсэн зохицуулалтыг хэзээ ч орлож чадахгүйг анхаарах хэрэгтэй.

Хүлээгдэж буй үр дүн нь: Уул уурхайн салбараас хэт хамаарал багасаж, экспортын орлого нэмэгдсэнээр удаан хугацааны эдийн засгийн тогтвортой өсөлттэй болно. Мөн олон улсад өрсөлдөх чадвартай компаниудыг дагасан жижиг дунд үйлдвэрлэл хөгжиж, ажилгүйдэл буурснаар эдийн засаг эрүүлжих нөхцөлүүд бүрдэнэ.

Улс	ГВУН ам.доллар
Хятад	3.2 их наяд
Япон	1.3 их наяд
Швейцарь	881 тэрбум
Америк	451.3 тэрбум
Орос	432.7 тэрбум
Энэтхэг	412.6 тэрбум
Өмнөд Солонгос	388.8 тэрбум
Бразил	374 тэрбум
Сингапур	285 тэрбум
Тайланд	202.5 тэрбум
Герман	200 тэрбум
Мексик	175.5 тэрбум
Монгол	3.02 тэрбум
Франц	156.3 тэрбум
Итали	151.1 тэрбум
Их Британ	150.9 тэрбум
Чех	148 тэрбум
Индонез	130.2 тэрбум
Польш	113.3 тэрбум
Израиль	113 тэрбум
Турк	107.7 тэрбум
Малайз	102.4 тэрбум
Канад	86.7 тэрбум
Филиппин	81.4 тэрбум
Дани	75.2 тэрбум
Испани	69.4 тэрбум
Австрали	66.6 тэрбум
Норвеги	65.9 тэрбум



Дэлхийн улс орны гадаад валютын улсын нөөцийн хэмжээ 2017 оны эцсийн байдлаар



Гадаад валютын улсын нөөц нь аливаа улс орны тусгаар тогтнолын баталгаа, үндэсний баялгийн нэг хэсэг бөгөөд үндэсний мөнгөн тэмдэгтийн үнэ цэнийг хадгалах, хямралын үед улс орны эрсдэл даах чадварыг хангах, гадаад өрийн үйлчилгээ хийх, хөрөнгө оруулагчдын итгэлийг хадгалахад чухал үүрэг гүйцэтгэдэг.

Эх сурвалж: Дэлхийн банк



МОНГОЛБАНКНЫ ХЭВЛЭЛИЙН БАГА ХУРАЛ 2018.08.29

Монголбанкнаас сар бүр зохион байгуулдаг хэвлэлийн бага хурал 2018.08.29-нд болж, 7 дугаар сарын банк, санхүү, эдийн засгийн статистикийг мэдээллээ. Мөн энэ үеэр цаг үеийн асуудлаар сэтгүүлчдийн сонирхсон асуултад тайлбар мэдээлэл өгснийг бүрэн эхээр нь танилцуулж байна.

BLOOMBERG TV MONGOLIA: ОНЫ ЭХНИЙ ДОЛООН САРД БИЗНЕСИЙН ЗЭЭЛ ЖИЛИЙН ДҮНГЭЭР 15 ХУВЬ ӨССӨН БАЙНА. ЭНЭ ӨСӨЛТИЙГ ХЭР ХАНГАЛТТАЙ ГЭЖ ҮЗЭЖ БАЙГАА ВЭ. ЦААШИД НЭМЭГДЭХ БОЛОМЖТОЙ ЮУ?

Судалгаа статистикийн газар (ССГ)-ын захирал Д.ГАН-ОЧИР:

Бизнесийн зээл сүүлийн 2-3 сарын хугацаанд нэлээн идэвхтэй өсөж байна. Энэ нь эдийн засагт маш нааштай үр дүн. Учир нь эдийн засгийн төрөлжилт, ажлын байр бий болгох, улмаар энэ нь цалин орлогын өсөлтөөр энгийн иргэдийн амьдралд нөлөөлдөг гол суваг. Тиймээс Монголбанк бизнесийн зээлийг дэмжих бодлого барьж байна.

Хэрэглээний зээлийн өндөр өсөлт өрхийн өрийн дарамтыг бий болгоно. Дараа нь сөрөг нөхцөл байдал болох үед өрхдөө ч, зээл олгосон санхүүгийн байгууллагадаа ч дарамттай байдаг. Энэ бол Монголын эдийн засгийг тогтворгүй болгож ирсэн гол хүчин зүйл. Тиймээс бид хэрэглээний

зээлийг бизнесийн зээлд шилжүүлэх Макро зохистой бодлогын хүрээнд өр орлогын харьцааг хязгаарлах шийдвэр гаргасан. Энэ шийдвэр 2019 оноос үр дүнгээ өгөөд эхэлбэл бизнесийн зээлийн өсөлт хангагдана гэж үзэж байна. Нөгөө талаас зээлийн нийлүүлэлт нэмэгдэх үндэслэл нь банкны системд зээл гаргах боломжтой эх үүсвэрүүд байна. Төв банкны үнэт цаасны хүрээнд зээл гаргах боломжтой эх үүсвэрийн хэмжээ 2 их наяд төгрөг байна. Тиймээс зээл цаашид өснө. Гэхдээ бизнесийн зээл рүү өсөлт нь чиглэнэ гэж харж байгаа.

BLOOMBERG TV MONGOLIA: ИНФЛЯЦИ 7 ДУГААР САРЫН БАЙДЛААР ТӨВ БАНКНЫ ЗОРИЛТОТ ТҮВШИН БОЛОХ 8 ХУВЬ ОРЧИМД ХҮРСЭН БАЙНА. ОЛОН ЖИЛИЙН ДУНДЖААР 7,8,9 ДҮГЭЭР САРУУДАД ИНФЛЯЦИ БУУРДАГ. ЭНЭ ЖИЛ ИНФЛЯЦИ БУУРААГҮЙН ШАЛТГААН ЮУ ВЭ. ЦААШИД ТӨВ БАНКНЫ ЗОРИЛТЫГ ДАВАХ ЭРСДЭЛ БИЙ ЮУ?

Мөнгөний бодлогын газар (МБГ)-ын захирал Б.БАЯРДАВАА:

7 дугаар сарын хамгийн өндөр инфляци Улаанбаатар хотод жилийн дүнгээр 8.8 хувьтай байна. Энэ инфляцид байгаль цаг уурын нөлөө гарч ирж байна. Ургацтай холбоотойгоор хүнсний ногооны үнэ өнгөрсөн жилээс хойш харьцангуй өндөр түвшинд хадгалагдсан. Өнгөрсөн жилийн ургац алдсантай холбоотойгоор хүнсний ногооны үнэ инфляцийн 1 нэгж хувийг дангаараа тайлбарлаж байна. Хоёрдугаарт хатуу түлшний үнэ өнгөрсөн оны мөн үеэс 60 орчим хувь өсөөд эргэж буураагүй нь инфляцийн 1.6 нэгж хувийг дангаараа тайлбарлаж байна. Гуравдугаарт, шатахууны үнэ инфляцийн 0.8 орчим хувийг тайлбарлаж байна. Дэлхийн зах зээл дээр нефтийн үнэ 70 орчим ам.долларт хүрсэн байгаа. Энэ өсөлт зөвхөн Монголд биш дэлхийн улс орнуудад ажиглагдаж байгаа нийтлэг үзэгдэл. Жишээ нь ОХУ нефть экспортлогч орон гэхэд дотоодод нь шатахууны үнэ өсөх хандлагатай байгаа. Дээр нь Засгийн газраас татвараар үнийг зохицуулж байсан ч орон зай хумигдсан байгаа. Дараагийн нэг хүчин зүйл нь махны үнэ. Махны үнэ энэ жил 7 дугаар сард буураагүй. Зуншлага, малын тарга тэвээрэг хойшилж, бороо их орсноос шалтгаалж нийлүүлэлтэд нөлөө үзүүлсэн. Нийт инфляцийн 1.1 нэгж хувийг махны үнэ дангаараа тайлбарлаж байна. Харин согтууруулах ундааны үнийн өсөлт инфляцийн 0.5 нэгж хувийг нь тайлбарлаж байна. Эдгээр таван бүтээгдэхүүн инфляцийн 5.5 нэгж хувийг дангаараа тайлбарлаж байна. Эдийн засаг сэргэж байгаатай холбоотой эрэлтийн талын хүчин зүйл бий. Ханшийн сулралын хоцрогдсон нөлөө ч явж байгаа. Гэхдээ эдгээрийн нийт инфляцид үзүүлж буй дарамт нь бага. ҮСХ-ны тооцсоноор суурь инфляци оны эхнээс 3.1 хувь байна. Ерөнхийдөө зорилтоос давах эрсдэл харьцангуй бага. Наймдугаар сард инфляци бууна гэж харж байгаа. Ялангуяа мах, хүнсний ногооны үнэ буурна. Тэгэхээр наймдугаар сард инфляцийн түвшин 8.8 хувиас буурна. Харин богино хугацааны төсөөллөөр оны эцэс гэхэд 7-7.5 хувийн инфляцитай байна гэсэн хүлээлттэй байгаа.

NEWS.MN: БАНКУУД АКТИВЫН ЧАНАРЫН ҮНЭЛГЭЭГЭЭР 512 ТЭРБУМ ТӨГРӨГИЙН ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ДУТАГДАЛТАЙ

ГАРСАН. ӨНГӨРСӨН САРЫН БАЙДЛААР 4 БАНК 124 ТЭРБУМ ТӨГРӨГӨӨР ӨӨРИЙН ХӨРӨНГӨӨ НЭМЭГДҮҮЛСЭН ГЭДЭГ МЭДЭЭЛЛИЙГ ӨГЧ БАЙСАН. ОДОО ҮЛДСЭН ХУГАЦААНД БАНКУУД ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ДУТАГДЛАА НӨХӨХ БОЛОМЖТОЙ ЮУ?

Хяналт шалгалтын газар (ХШГ)-ын захирал Н.БАТСАЙХАН:

Банкууд өөрийн хөрөнгийн дутагдлаа нэмэгдүүлэх арга хэмжээ авч ажиллаж байгаа. Оны эцэс хүртэл Монголбанкнаас өгсөн хугацаанд үлдсэн өөрийн хөрөнгийн хэмжээг бий болгох бүрэн боломжтой. Банкууд өөрийн хөрөнгөө цэвэр мөнгөн хөрөнгөөр нэмэгдүүлдэг.

NTV ТВ: БОНДУУДЫН ТӨЛБӨРИЙГ ГҮЙЦЭТГЭХДЭЭ ХАНШИЙН ЗӨРҮҮНЭЭС ХҮЛЭЭСЭН АЛДАГДЛЫГ ТӨВ БАНК ТООЦОЖ ГАРГАДАГ БОЛОВ УУ?

ССГ-ын захирал Д.ГАН-ОЧИР:

Монгол Улсын Засгийн газар, ААН-үүдийн гаргасан бондын ханшийн зөрүүнээс хүлээсэн алдагдал тухайн байгууллагынхаа баланс дээр алдагдал хэлбэрээр тусдаг байгаа. Төв банкны зүгээс ханшийн зөрүүтэй холбоотой статистик тооцоог албан ёсоор хийдэггүй.

ММ АГЕНТЛАГ: ЗЭЭЛИЙН ХҮҮГ УРЬДЧИЛЖ АВАХЫГ ХОРИГЛОСОН ТАЛААРАА МЭДЭЭЛЭЛ ӨГӨӨЧ?

ХШГ-ын захирал Н.БАТСАЙХАН:

Хүүг урьдчилж авч байна гэсэн гомдол байдаг. Монголбанкнаас “Банкны хүү бодох аргачлал, хүү, шимтгэл, хураамжийн мэдээллийн ил тод байдлын журам”-ыг шинэчилж баталсан. Энэхүү журмын дагуу банкууд хүүг урьдчилж авахыг хориглосон. Мөн банкууд харилцагчиддаа нийт өртгийг шингээсэн бодит зээлийн хүүг мэдээлэх үүрэг хүлээсэн байгаа. Тэгэхээр энэ журмын дагуу хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах тодорхой арга хэмжээнүүд авсан. Журам 7 дугаар сарын эцсээр батлагдсан учраас Монголбанк хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллана. Хяналт шалгалт хийгээд зөрчил илэрсэн бол журманд заасны дагуу арга хэмжээ авна.



“Үндэсний шуудан” сонин: долларын ханш 2500 төгрөгтэй тэнцэж байгаа шалтгааныг та бүхэн тайлбарлана уу?

Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газар (НУСЗЗГ)-ын захирал А.ЭНХЖИН:

Монгол Улсын валютын ханш эдийн засгийн суурь нөхцөлтэй нийцтэйгээр уян хатан тогтох зарчимтай. Үүнээс зөрж огцом савлагаа үүссэн тохиолдолд Монголбанк оролцдог. Эдийн засгаа харвал урсгал данс байнга алдагдалтай явж ирсэн. Энэ нь ханшид дарамт учруулдаг. Монгол Улсын гадагш экспорт хийж олж байгаа орлого нь импортын зардлаасаа бага байна. Манай улсын эдийн засаг төрөлжөөгүй, зөвхөн уул уурхайн түүхий эдээс хамааралтай байна. Эдийн засгаа том дүр зургаар нь харвал эдийн засгийг төрөлжүүлэх, импортыг орлох салбаруудыг хөгжүүлэх тал дээр Засгийн газраас бодлогын арга хэмжээ авах шаардлагатай байна.

Ханшийн цаашдын төлвийн тухайд импортын өсөлт 40 хувь байгаа ч 30 орчим хувь нь эдийн засгийн өсөлтийг дэмжих хөрөнгө оруулалтын шинжтэй байна. Нөгөө талаас ГВАН харьцангуй өндөр 2.9 тэрбум ам.доллар байгаа нь Монголбанкнаас ханшийг тогтвортой байлгах боломжтой гэж үзэж байна. Мөн өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн хүрээнд Монгол Улсад орж ирэх санхүүжилтүүд цаг

хугацаандаа орж ирвэл ГВАН нэмэгдэнэ. Төлбөрийн тэнцэл оны эцэст 200-300 сая ам.долларын ашигтай гарах төлөвтэй байна. Энэ бүхнээс үзэхэд ханш тогтвортой байх хүлээлттэй байна.

МОНГОЛ ТВ: АРИЛЖААНЫ БАНКУУДАД 8 ХУВИЙН ЗЭЭЛТЭЙ ХОЛБООТОЙ ШАЛГАЛТ ХИЭСЭН ҮҮ. ХИЭСЭН БОЛ ШАЛГАЛТЫН ДҮНГИЙН ТАЛААР МЭДЭЭЛЭЛ ӨГӨӨЧ?

НУСЗЗГ-ын захирал А.ЭНХЖИН:

Энэ оны хувьд арилжааны банкууд дээр Активын чанарын үнэлгээ, Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр, Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой асуудлаар тодорхой шалгалтууд хийж байна. Арилжааны банкуудад олон шалгалт хийх нь ажилд нь хүндрэл учруулж болзошгүй учраас Ипотекийн хөтөлбөрт шалгалт хийхийг хойшлуулсан. Монголбанкинд гомдол, саналууд ирдэг. Энэ ондоо багтааж бид арилжааны банкуудад тодорхой ажлууд хийхээр төлөвлөж байна.

GOGO.MN: ВАЛЮТЫН ЦЭВЭР НӨӨЦИЙН ХЭМЖЭЭГ ХЭЛНЭ ҮҮ?

НУСЗЗГ-ын захирал А.ЭНХЖИН:

Төв банк валютын цэвэр нөөцийн хэмжээг зарладаггүй. Харин Гадаад валютын албан нөөцийн хэмжээ 6 дугаар сарын эцсийн байдлаар 2.9 тэрбум ам.доллар байгаа. Энэ нь 2017 оны эхэн үетэй харьцуулбал бараг 3 дахин өссөн үзүүлэлт юм.




Мөнгөний нийлүүлэлт

Зураг 2.3. Мөнгөний нийлүүлэлтийн бүтэц



Зээл

Зураг 2.4. Нийт хадгаламж




- Нийт M2 мөнгөний нийлүүлэлтийн 54.4%-ийг ₮-ийн хадгаламж бүрдүүлж байгаа бол 15.4%-ийг валютын хадгаламж, 14.3%-ийг ₮-ийн харилцах, 12.2%-ийг валютын харилцах, үлдсэн %-ийг хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө бүрдүүлж байна.
- Нийт хадгаламжийн хэмжээ 12 их наяд ₮-т хүрснээс 83.2%-ийг иргэдийн хадгаламж, 16.8%-ийг байгууллагын хадгаламж бүрдүүлж байна.
- Иргэдийн хадгаламжийн 19%-ийг, байгууллагын хадгаламжийн 37.2%-ийг гадаад валютын хадгаламж бүрдүүлж байна.




Мөнгөний нийлүүлэлт

Зураг 2.7. Нийт зээлийн бүтэц



Зээл

Зураг 2.8. Зээлийн жилийн өсөлт, сектороор




- Банкуудын зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 19.5 %-иар өсч 15.5 их наяд ₮-т,
- Иргэдэд олгосон зээлийн үлдэгдэл 24.8 %-иар өсч 7.6 их наяд ₮-т,
- Хувийн байгууллагынх 15.7 %-иар өсч 7.8 их наяд ₮-т тус тус хүрчээ.




Зураг 2.11 Чанаргүй зээл (салбараар)

Нийт чанаргүй зээлийн 82.2%-ийг хувийн байгууллагад олгосон зээл бүрдүүлж байна.



Зураг 2.12 Хугацаа хэтэрсэн зээл (салбараар)

Нийт хугацаа хэтэрсэн зээлийн 83.2%-ийг хувийн байгууллагын зээл бүрдүүлжээ.



Зураг 3.1. Тайлант сард олгосон зээл болон зээлийн үлдэгдэл



Зураг 3.2. Ипотекийн зээлийн жилийн өсөлт



Тайлант сард 46.9 тэрбум ₮-ийн ипотекийн зээлийг 629 иргэнд олгосон байна. Үүнээс:


- Орон нутагт 6.3 тэрбум ₮-ийн ипотекийн зээлийг 167 иргэнд олгожээ.

Ипотекийн зээлийн үлдэгдэл 4.3 их наяд ₮-т, зээлдэгчдийн тоо 93,885-т хүрчээ. Үүнээс:

- Нийт ипотекийн зээлийн үлдэгдлийн 17.6%-ийг орон нутагт олгосон зээл байна.
- Орон нутагт 25,030 иргэдийн 762.1 тэрбум ₮ зээлийн үлдэгдэлтэй байна.



4.1. Төлбөрийн тэнцлийн статистик, 2018 оны эхний 6 сар





РЭНДОЛФ КОППА: **БАНКИР Ч ГЭЛТГҮЙ АЛИВААД "ХЭРЭВ" ГЭСЭН ӨНЦГӨӨР ХАРДАГ БАЙВАЛ САЙН**

Худалдаа хөгжлийн банкны ТУЗ-ийн гүйцэтгэх дэд захирал Рэндолф Коппатай ярилцлаа.

Ноён Рэндолф Коппа Танд энэ өдрийн мэндийг хүргэе. Хүсэлтийг хүлээж авч ярилцлага өгөх болсонд талархаж байна. Бид ярилцлагаа Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдлын талаар эхлэх нь зүйтэй болов уу.

Болж байна. Тэгэхээр, Монгол Улсын эдийн засаг сүүлийн 18 сарын хугацаанд нэлээд сайжирч, эдийн засгийн өсөлт, гадаад валютын нөөц, гадаад худалдааны тэнцэл зэрэг санхүү эдийн засгийн гол тоон үзүүлэлтүүд нэмэгдэж, сайжрахын хажуугаар инфляци удирдаж болохуйц түвшинд хадгалагдаж чадаж байна. Мөн төсвийн удирдлага сайжирч, экспорт тэр дундаа нүүрсний экспорт тээврийн зарим асуудлаас үл хамааран нэмэгдэж байна. Энэхүү эдийн засгийн эерэг өөрчлөлтөд Оюу Толгойн гүний уурхайн

хоёр дахь шатны санхүүжилт тодорхой нөлөө үзүүлж байгаа нь дамжиггүй. Улмаар энэ нь уул уурхайгаас хамааралтай бусад салбаруудад эерэгээр нөлөөлж байна. Тиймээс ерөнхий дүр зургаар бол эдийн засаг 6 орчим жилийн өмнөх шиг ихээхэн сэргэлттэй байгаа.

ОУВС-ийн хөтөлбөрийн хүрээнд банкны салбарт Активын чанарын иж бүрэн үнэлгээг Европын төв банкны аргачлалаар хийсэн үр дүнгийн талаар та юу хэлэх вэ?

Миний бодлоор Активын чанарын үнэлгээ нь өөрөө маш зөв ажил болсон. Учир нь гадаадын хөрөнгө оруулагчид Монгол Улсыг ажиглаж байгаа энэ цаг үед ОУВС-ийн хөтөлбөрийн хүрээнд тус үнэлгээг хийснээр банкуудын олгосон зээл нь барьцаа хөрөнгийн үнэлгээтэй хэр дүйцэж байгааг харуулсан. Монголын банкны салбарын

2016-оноос

ХХБ-ны ТУЗ-ын Гүйцэтгэх дэд дарга

2007-2016 он

ХХБ-ны Ерөнхийлөгч

2004-2007 он

ХХБ-ны Гүйцэтгэх захирал

Тэрбээр нийт 12 оронд ажиллаж байсан ба ХХБ-нд орохоос өмнө 16 жил Ай Эн Жи Банкинд ажилласан.

1964 он

Висконсиний Их Сургуулийг Гадаад харилцааны чиглэлээр төгссөн

хувьд хөгжингүй орнуудтай харьцуулахад мөнгөн урсгал эсвэл зээлийн зэрэглэл дээр биш ихэвчлэн барьцаа хөрөнгө дээр үндэслэж зээл олгодог. Гадаадын экспертүүд зээлийн дүн болон барьцаа хөрөнгийн үнэлгээний хооронд ихээхэн зөрүү байна гэж эргэлзэж байсан бол Активын чанарын үнэлгээний үр дүнгээр нөхцөл байдал тийм биш юмаа гэдгийг харуулсан.

Тэгэлгүй яахав, Активын чанарын үнэлгээний үр дүн Монголбанкнаас төсөөлж, урьдчилан таамаглаж байсантай нийцтэй гарсан.

Тийм шүү. Энэ нь Монголбанкны хяналт шалгалт хэр сайн байгааг харуулж байгаа юм. Мөн арга зүйн хувьд Активын чанарын үнэлгээг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС) -ийг мөрдлөг болгож хийсэн учраас Монголын банк санхүүгийн салбарт хийгдэх гэж байгаа санхүүгийн тайлагналын шинэчлэлд бэлдэж өгсөн давуу талтай.

Гэхдээ нөгөө талаар банкуудын зээлийн багцад сул тал байгааг харуулсан. Тухайлбал банкууд уул уурхай болон барилга зэрэг салбаруудад төвлөрөн, багагүй зээл олгосон нь эдийн засаг хүндрэх үед асуудал үүсгэсэн.

“Банкны салбарын тогтвортой байдлыг хангах тухай хууль” юм. Олон Улсад энэ чиглэлийн хууль эрх зүйн орчин бий болсноор хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах боломж

бүрдсэн. Энэ талаар тодруулж өгнө үү?

Миний бодлоор моргейжийн зээлийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цааснаас үүдэлтэйгээр Олон Улсын санхүүгийн томоохон хямрал болох үед зарим улсууд үүнд бэлэн бус байсан. Аливаа асуудал, хүндрэл тулгарч ирэхэд түүнд бэлтгэлтэй байх нь чухал. Ялангуяа хүндрэл тулгарахад Засгийн газар, Төв банк нь ямар үүрэгтэй оролцохыг тодорхой заах нь маш чухал.

Өнгөрсөн 7 дугаар сард Монголоос ажлын хэсэг жил бүр болдог APG-ийн хуралд оролцоод ирсэн бөгөөд үр дүнд нь Монгол Улсыг FATF-ийн “саарал жагсаалт”-нд оруулах эсэхийг шийдвэрлэх хугацааг дахин 12 сараар сунгуулсан. Банкны салбарт энэ нь хэрхэн нөлөөлж байгаа вэ?

Үнэнийг хэлэхэд нөлөөлөл нь эртнээс мэдрэгдэж эхэлсэн. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаа нь Олон Улсыг хамарч байгаа бол зарим оффшор санхүүгийн бүс, тухайлбал Швейцарын банкууд зайгаа барьж эхэлсэн. Энэ нь гэнэт бий болчихоогүй бөгөөд өнгөрсөн 10 гаруй жилийн хугацаанд болгоомжлол нэмэгдэж, зарим томоохон банкууд ч мөнгө угаах болон терроризмийг санхүүжүүлэхтэй тэмцэхтэй холбоотой асуудалд орж, их хэмжээний торгуул төлсөн

тохиолдлууд бий. Нөгөөтэйгүүр хянан нийцүүлэх шаардлага тулгарсан тул банкуудын олон улсын гүйлгээний шимтгэл зэрэг банкны өдөр тутмын үйл ажиллагааны зардал илүү өндөр болоод байна. Ийм өндөр зардал гарч байгаа нөхцөлд гадаадын банкууд Монголын зах зээлийг жижиг бөгөөд авилга болон мөнгө угаах, терроризмтэй тэмцэх зэрэглэлээр тийм ч сайнгүй гэдэг үндэслэлээр зайгаа барьдаг. Монголоос зайгаа барьж байгаа нь Монгол Улс ямар нэг зүйл хийсэн эсвэл хийгээгүйд биш, Олон Улсын банкууд шалгуураа чангаруулсанд байгаа юм. Гэхдээ ХХБ-ны зүгээс үүн дээр идэвхтэй ажиллаж, хамтын ажиллагаагаа сайжруулж ирсэн. Шри Ланк Улсад APG-ийн хурал 2017 оны 7-р сард болсон бөгөөд үр дүнд нь Монгол тодорхой үүргийг авсан ба томоохон ажлуудыг авч хэрэгжүүлээд байна. Саарал жагсаалтад оруулах эсэхийг 12 сараар сунгасан нь сайн зүйл ч Олон Улсын банкууд болгоомжилсон хэвээр байгаа.

Монголбанкнаас “Зээлийн хүүг бууруулах үндэсний стратеги”-ийг боловсруулж, бусад байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж эхлээд байгаа. Судалгааны ажлуудаас уншихад зээлийн хүүг бууруулах олон арга байдгаас хамгийн сүүлийх нь тааз тогтоох явдал юм гэсэн байна. Таны бодлоор зээлийн хүүд тааз тогтоох нь хэр зохимжтой вэ?



АНУ-ын Bank of America-д анх ажилд орж байхад намайг орон нутгийн салбарт томилж байсан. Тухайн үед би олон улс хариуцсан мэргэжилтнээр ажиллах хүсэлтэй байсан ба зээл, хадгаламжийн хүүг төдий л сайн хайхардаггүй байж. Гэтэл яах ч аргагүй зээл дээр ажиллах хэрэг гарсан юм. Тэр үед "Regulation Q" хэмээх журмын хэрэгжилтийн хүрээнд хадгаламжийн хүүнд хязгаар тогтоож байсан. Нөгөө талаас АНУ-ын Холбооны нөөцийн банкнаас зарим нэг зээлийн хүүг зохицуулж байлаа. Энэ нь эдийн засагт тогтворгүй байдал үүсгэж байсан тул Regulation Q хүчингүй болгосноор хадгаламжийн хүүнд тааз тогтоохоо больсон. Улмаар мөнгөний зах илүү нээлттэй болж, хүүгийн хязгаарлалтууд суларснаар эдийн засагт дэмжлэг үзүүлж эхэлсэн. Зайлшгүй тохиолдолд хадгаламжийн хүүд тааз тогтоох нь илүү үр дүнтэй байж болно. Учир нь хадгаламжийн хүү гэдэг нь эх үүсвэрийн зардал болохоор зээлийн хүүд шууд нөлөөлж байдаг. Инфляци харьцангуй нам түвшинд байхад, хадгаламжийн хүү хоёр оронтой байсаар л байна. Шинээр байгуулагдсан банкууд хоорондоо хадгаламжийн хүүгээр өрсөлдөж ирсэн нь зах зээлийн зарчим мэт болсон байж магадгүй. Гэхдээ бид зээлийн хүүг бууруулж, эрсдэлийн зөрүүг шахах нь зохистой зүйл биш юм. Тиймээс миний туршлагаас харахад зээлийн хүүд ерөнхийд нь хиймлээр тааз тогтоох нь дунд хугацаандаа боломжгүй

юм. Зээлийн хүүг бууруулахад мөнгөний бодлого чухал бөгөөд нөгөө талаас төсвийн бодлого чанга байж, үр ашиггүй зарцуулалт, инфляцийн дарамтыг хязгаарлахад томоохон нөлөөтэй.

Эдийн засаг, Монголын банкны салбарын талаар ярьсан бол одоо таны ажил мэргэжлийн онцлогийн талаар яривал ямар вэ. Та Монгол Улсад 2004 оноос хойш ажиллаж байна. Түүнээс өмнө ямар алба хашиж байсан бэ?

Миний хувьд банкны салбарт нийт 50 жил ажилласан бөгөөд түүний 14 жилийг Монголд өнгөрүүлжээ. Миний ажлын гараа АНУ-ын Калифорни муж дахь Bank of America-ын төв оффист дадлагажигчаар ажиллаж

эхэлснээр тавигдсан. Би Европ тив рүү явах хүсэлтэй байсан ч надад аз дайрч Зүүн Өмнөд Азийн салбарт томилогдсон. Тэгээд Сингапур улсад Ли Куан Югийн дэглэм ноёрхож байхад хэсэг хугацаанд ажиллаж байгаад Европ руу шилжиж, Грек, Нидерланд, Италид ажилласан. Би 1990 онд Польш Улсад банк нээн ажиллаж байгаад ING банкинд шилжин орсон. ING-д байхдаа мөн БНХАУ, Хонг Конг, Япон зэрэг улсуудыг хариуцан ажиллаж байсан туршлагатай. ING банкны гэрээний дагуу Монгол Улсын ХХБ-нд менежмент болон техникийн туслалцаа үзүүлэх болсноор энд ирсэн. Тухайн үед богино хугацааны даалгавартай байсан ч би Монгол Улсад үлдэхээр шийдэж одоо 14 гаруй жилийг ардаа үдсэн байна.

Миний ажиллаж байсан газрууд ихэвчлэн хөгжиж байгаа буюу франтиер зах зээл байсан. Хэдийгээр Сингапур, Грек, Хонг Конг, БНХАУ өнөөдөр хөгжлөөр манлайлж байгаа ч намайг анх очиж байхад мөн л франтиер ангилалд багтдаг байсан.

Монголд ажиллахад юу танд илүүтэй таалагддаг вэ?

Надад хамгийн их таалагддаг зүйл нь шинэ бүтээгдэхүүн, технологи нэвтэрч байгаад юм. Би Монголын Ипотекийн Корпорацийн Төлөөлөн удирдах зөвлөлийндаргаар бжилажиллаж, орон сууц барьцаалсан зээлийн хоёрдогч зах зээлийг эхлүүлэх болон орон сууц барьцаалсан үнэт цаасыг хөрөнгө оруулагчдад санал болгох ажлуудад оролцсон. Миний хувьд Монгол Улсад шинэ бүтээгдэхүүн, зах зээл бий болгох нь мэргэжлийн хүний хувьд ихээхэн урамтай санагддаг.

Та яагаад банкир болох замыг сонгосон бэ?

Намайг бага байхад банкир болох нь миний зорилго байгаагүй. Анх 8 настай байхдаа би шуудангийн марканд татагдаж эхэлсэн бөгөөд улмаар цуглуулагч болсон. Эхэндээ АНУ-ын маркуудыг цуглуулж байсан бол удалгүй гадаад маркууд миний цуглуулгад багтах болсон. Энэ нь цаашлаад надад дэлхийн газар зүй, олон улсын харилцааг сонирхох сэдлийг өгсөн. Би гадаадын улс орнуудад ажиллаж амьдрах хүсэлтэй байсан учраас их сургуульд элсэж орохдоо

гадаад харилцааны салбарыг сонгосон. Гэвч төгссөний дараа мөн л гадаадад ажиллах боломжтойг нь харгалзан банкир болохоор шийдсэн. Гэхдээ би нягтлан гэхээс илүү эдийн засгийн чиглэлээр мэргэшсэн байсан учраас, анх Bank of America-д ажиллаж эхлэхэд нягтлангаар суралцах шаардлага тулгарсан. Тэд Калифорнийн их сургуультай хамтран шинээр ажилд орсон ажилтнууд, дадлагажигч нартаа нягтлангийн курсэд суухыг санал болгодог. Нягтлан бодох бүртгэл бол банкны үндсэн хэл бөгөөд мөн зарим талаар бизнесийн хэл гэж болно. Одоо бид СТОУС 9-ийг хэрэгжүүлэх шаардлага тулгарч байгаа тул үргэлжлүүлэн сурах нь зайлшгүй шаардлагатай болж байна.

Та өөрийн өдөр тутмын ажлын талаар танилцуулна уу. Бидэнд их сонирхолтой санагдаж байна.

Миний ажлын нэг үндсэн чиглэл нь банкны олон улсын харилцааг хариуцаж ажиллах учраас өдөр тутмын ажилд маань гадаадын зочид, хөрөнгө оруулагч нартай уулзалт хийх нь томоохон байр суурь эзэлдэг. ХХБ-ны бондод гадаадын олон хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулсан учраас тэдэнтэй уулзаж, мэдээлэл өгөх нь зайлшгүй хийх ажил юм. Дашрамд хэлэхэд энэ хүрээнд Сингапур болон Хонг Конгийн хөрөнгө оруулагчдаас бүрдсэн баг маргааш (08-р сарын 24) хүрэлцэн ирж байгаа. Мөн зээлжих зэрэглэл тогтоогч

агентлагуудын төлөөлөл, магадлан шинжилгээ /due diligence/, олон талт хэлэлцээрүүд хийх гэх мэт гадаад харилцаатай холбоотой уулзалт, ажлуудыг хийдэг. Нөгөө талаас би өөрөө гадаад улсуудад ажиллах тохиолдол их бөгөөд нэг ёсондоо банкыг болон Монгол Улсыг төлөөлөх "Элч" мэт үүргийг гүйцэтгэдэг. Дээр дурдсан зүйл бол илүүтэйгээр гадагш чиглэсэн ажлууд. Би мөн банкны дотоод зөвлөхийн ажлыг гүйцэтгэдэг. Зарим талаар энэ нь менторийн үүрэг болж хувирдаг. Үүнд гүйлгээний, баримтжуулалтын, бүтцийн зэрэг зөвлөгөө багтана. Би бизнесийн хүрээллийнхний дунд ажиллах сонирхолтойн хувьд мөн Монголын бизнесийн зөвлөлийн удирдах зөвлөлийн даргын албыг хашиж байгаа. Цаашлаад Америкийн болон Австралийн худалдааны тэнхимүүдийн удирдах зөвлөлийн гишүүнээр тус тус ажиллаж байна.

Та сая менторингийн талаар дурдлаа. Залуу мэргэжилтэнд зөвлөж, зааж сургах хүн байна гэдэг маш чухал бөгөөд хувь нэмэртэй байдаг. Таныг ажлын гараагаа дөнгөж эхэлж байхад ментор байсан уу?

Тэгэлгүй яах вэ. Намайг залуу боловсон хүчин байх үед надтай хамт ажилладаг туршлагатай хамтран зүтгэгч нар маань надад харамгүй зааж, зөвлөдөг байсан. Зарим нь илүү том дүр зургаар, стратегийн түвшинд харахад зааж

сургасан бол зарим илүүтэйгээр өдөр тутмын ажил зөвлөдөг байсан. Ялангуяа миний ахлах байсан ахимаг насны хүн надад хэрхэн товч бөгөөд тодорхой бичихэд зааж сургасан. Урд цагт өнөөдрийнх шиг имэйл, интернет зэрэг харилцааны хэрэгслүүд байгаагүй л дээ. Бид гадаад мэдээ хүргэх бол кабел буюу телеграм маягийн хэрэгслээр дамжуулдаг байсан. Тэгэхлээр би 10 үгтэй мэдээ бичлээ гэхэд ахлах маань түүний талыг нь хар балаараа дараад илгээх тохиолдол олон байсан. Энэ нь нэг талаар өвөрмөц хэлбэрийн заах арга барил бөгөөд цаагуураа тодорхой байхад сургасан. Би Bank of America-д 5 орчим жил ажиллаад Чикаго хот дахь Continental Illinois банкинд шилжиж орсон. Тус банк нь байгууллагын банк буюу ихэвчлэн маш том корпорациудад зээл олгох үйлчилгээ үзүүлдэг байсан юм. Тэнд очоод надад компанийн санхүүгийн тайланг нэгд нэгэнгүй уншиж сурах шаардлага тулгарсан. Учир нь Bank of America-д ажиллаж байсан эхний жилдээ би зээлийн мэргэжилтэн байсан бөгөөд миний санхүүгийн шинжээчийн чадвар дөнгөж хөгжиж байсан хэрэг. Тиймээс Continental Illinois банкинд ажиллаж байсан ахлах ажилтнууд маань надад бодит утгаар нь

багшилсан. Ний нуугүй хэлэхэд тэд их хатуу ханддаг байсан шүү. Цаас шидэх явдал тохиолддог байсан. Болохгүй зүйлсийг дахин дахин хийлгэдэг. Монголын хувьд би өөрөө илүү дипломат арга барилаар хүмүүст зааж сургахыг хичээдэг. Монголчууд гэлтгүй Ази мэргэжилтнүүд дунд түгээмэл ажиглагддаг зүйл бол бодлоо шууд илэрхийлдэггүй явдал юм. Ямар нэг шинэ санаа гаргах ажил дээр би хатуу хандахаас илүү шинэ санаа бүхий ноорог бэлдэх даалгавар өгдөг. Тэдгээр санаанууд дээр зарим нэг заавар, зөвлөгөө өгснөөр залуу мэргэжилтнүүдэд их тус дэмтэй байдаг.

Энд хүрээд ярилцлагынхаа гол сэдвийг үүгээр өндөрлөө. Харин та төгсгөлд нь монголын залуу банкируудад зөвлөгөө өгнө үү.

Миний бодлоор банкны салбарын хөгжил тэр дундаа харилцагчийн банкны үйл ажиллагаа нь технологийн дэвшлээс сүүлийн жилүүдэд ихээхэн хамааралтай болжээ. Бүх зүйлс дижитал болж буй энэ цаг үед технологийн дэвшилтэй хөл нийлүүлж алхах нь зайлшгүй зүйл болсон. Залуучууд харьцангуй дасан зохицох чадвартай байдаг учраас эдгээр чадварыг эзэмшихэд

хүндрэл бага байх. Гэхдээ хамгийн гол нь банкны үйлчилгээ ихэнх улсуудад зээл олголтод төвлөрсөөр ирсэн. Үүнд Монгол ч мөн багтана. Тэгэхээр өрхийн хэрэглээний эсвэл байгууллагын гэлтгүй аливаа зээл олголтод кредит болон андеррайтерийн шинжилгээнд суралцах нь чухал юм. Тухайлбал кредит скоринг буюу зээлийн үнэлгээний зарчмыг нэвтрүүлж суралцах нь зайлшгүй хийх ёстой зүйл.

Түүнчлэн дан ганц технологи эсвэл тогтолцоонд найдах нь буруу. Хар хайрцаг байх ёстой. Монголчуудад шүүмжлэлт сэтгэлгээг төлөвшүүлэх нь маш чухал. Миний нэг хэвшил болсон зүйл бол, би аливаа шийдвэр гаргахдаа үргэлж өөрөөсөө асуулт асуудаг. Яагаад эсвэл чи яг итгэлтэй байна уу гэх мэт. Би хамтарч ажилладаг хүмүүсээсээ ч ингэж асуух нь түгээмэл бөгөөд хамгийн гол нь бидний хийж байгаа ажил эрсдэлд суурилсан бизнес. Бид эрсдэлийг тооцоолж, удирдснаараа цалин авдаг хүмүүс. Тэгэхээр дан банкир гэлтгүй Монгол залууст зөвлөхөд юмыг нэг талаас нь биш, хэрэв гэсэн байдалтайгаар өөр өнцгөөс харж, ажиллаж сурахыг зөвлөх байна.

Цаг зав гаргаж бидэнд сонирхолтой ярилцлага өгсөн танд баярлалаа.

МОНГОЛБАНКНЫ ЭРДЭНЭСИЙН САНГААС

ГОЛТ ЦӨГЦ

ХІХ - ХХ зуун

Жин: 692 гр

Өндөр: 14 см

Голч: 10 см

1984 оны 4 дүгээр сарын 26-нд Богд Хааны Ордон Музейгээс шилжин иржээ.

Эрхэн чимэг хээ бүхий бүслүүр болон давхар бад суурьтай мөнгөн цөгц. Бумба хэлбэрийн хүзүүнээс гарсан оюу шигтгээ бүхий унжлага чимэгтэй ажгуу. Бурханы шашны зан үйлийн хэрэгсэл нь дотроо тахилга өргөлийн буюу тахилын бумба, рашааны завьяа, гүц, тахилын цөгц, бойпор, түй мандал, мандал, толь тосгуур, цар таваг зэрэг янз бүрийн хэлбэр хийцтэй өргөл чимэглэлийн хэрэгсэл, мөн цам болон хурал номын үед хэрэглэгддэг эгшигт цан, сэлнэн, хонх дамар, харанга, дуударам, гандан бүрээ, бишгүүр тэргүүтэн шашны хөгжмийн зэмсгийн, очир, пүрэв, лянгань багаж, маанийн хүрд зэрэг тусгай зан үйлийн хэмээн ялгагдана. XVII -XX зууны эхэн хүртэл Богд Жавзандамба хутагтын орд өргөө болон Их хүрээний зарим тахилгатай газруудад хамаарч байсан монгол уран дархчуул сан /жас/-гийн хөрөнгө мөнгөөр шашны хурал, номын хийгээд бусад өдөр тутмын хэрэглээний зүйлсийг гууль, зэс, пойлоос, хүрэл, цас, алт мөнгөөр урладаг байжээ.



ЗЭЭЛИЙН ХҮҮГ БУУРУУЛАХ СТРАТЕГИЙН ҮНДЭСЛЭЛ, ШААРДЛАГА



Монголбанкнаас улирал бүр эрхлэн гаргадаг "МӨНГӨ-САНХҮҮ-БАЯЛАГ" сэтгүүлийн зургаа дахь дугаараас онцлов.

Банкны салбарын зээлийн хүү 2000-2012 онд тогтвортой буурч байсан бол сүүлийн зургаан жилд өсөх хандлагатай буюу жигнэсэн дундаж хүү нь жилийн 20 орчим хувьтай байна. Зээлийн хүүний энэ түвшинг бага орлоготой орнуудынхтай харьцуулахад харьцангуй бага түвшинд байгаа боловч Монгол Улсын орлогын ангилал болох дундаас доогуур орлоготой орнуудын дундажтай харьцуулахад 5 нэгж хувь, Зүүн Ази, Номхон Далайн орнуудын дундажтай харьцуулахад 10 гаруй нэгж хувиар өндөр байна. Манай орны эдийн засагт зээлийн хүү нь хөрөнгө оруулалт, бизнес эрхлэлтийг дэмжихүйц түвшинд хүртэл буурахгүй байгааг сүүлийн хориод жилийн турш байнга ярьж, холбогдох бодлогын баримт бичиг гаргаж хэрэгжүүлсэн хэдий ч зээлийн хүү өндөр хэвээр байна. Иймд зээлийн хүүг цаашид хэрхэн бууруулах арга замыг эрэлхийлэх, бодлого болоод стратегийн хүрээнд ямар арга хэмжээ авах

шаардлагатайг тодорхойлох нь чухал байна. Иймд зээлийн хүү буурахад шаардлагатай эдийн засаг, санхүү, эрх зүйн суурь орчны талаар үндэсний нэгдсэн ойлголцлыг бий болгож, бодлогын харилцан уялдааг хангахын тулд энэхүү 2018-2023 оны стратеги, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулсан болно.

АЛСЫН ХАРАА

"Зээлийн хүүг бууруулах стратеги - 2018-2023" нь бизнес эрхлэх санхүүгийн таатай орчныг бүрдүүлэх, санхүүгийн салбарын хүртээмжийг нэмэгдүүлэх, эдийн засгийн тогтвортой өсөлтийг бий болгох алсын зорилготой юм.

ЭРХЭМ ЗОРИЛГО

Энэхүү стратегийн эрхэм зорилго нь зээлийн хүү буурах макро эдийн засгийн орчныг бүрдүүлэх, бодлогын үр нөлөөг нэмэгдүүлэх (бодлогын хүүний шилжих сувгийг хүчтэй болгох), арилжааны банкны эрсдэл даах

чадвар, үр ашиг, засаглалыг сайжруулахад чиглэсэн үр дүнтэй үйл ажиллагаа явуулах замаар зээлийн хүүг бууруулахад оршино. Энэхүү стратеги амжилттай бүрэн хэрэгжсэнээр 2023 оны төгсгөлд банкны зээлийн жигнэсэн дундаж хүүг адил орлоготой бусад орны түвшинд хүргэх буюу одоогийн түвшнээс 5-7 нэгж хувиар бууруулах зорилт тавьж байна.

СТРАТЕГИЙН ЗОРИЛТ

Стратегийн зорилт нь зээлийн хүү буурах макро орчныг бүрдүүлэх, мөнгөний бодлогын хүүний шилжих нөлөөг нэмэгдүүлэх, банкны салбарын эрсдэл даах, үр ашиг, засаглалыг сайжруулахад шаардлагатай эрх зүй, удирдлага, үйл ажиллагааны үр дүнтэй арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэсэн болно. Энэхүү стратеги нь агуулгын хувьд стратегийн 11 зорилтыг агуулсан дараах үндсэн гурван хэсгээс бүрдэнэ.

Зээлийн хүү буурах макро эдийн засгийн тогтвортой орчныг бүрдүүлэх хүрээнд:

ЗОРИЛТ 1: Инфляцийг тогтвортой, нам түвшинд байлгах-инфляцийн зорилтот түвшинг хангах.

ЗОРИЛТ 2: Гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх, улсын гадаад өрийн тогтвортой байдлыг хангах.

ЗОРИЛТ 3: Төсвийн сахилгыг хангах, макро бодлогын уялдааг сайжруулах.

ЗОРИЛТ 4: Эдийн засгийг төрөлжүүлэх, дотоод хуримтлалыг нэмэгдүүлэх.

Мөнгөний бодлогын хүүний хадгаламж, зээлийн хүүнд шилжих нөлөөг сайжруулах хүрээнд:

ЗОРИЛТ 5: Бодлогын хүүний коридорыг ашиглан хүүний сувгийн нөлөөг сайжруулах.

ЗОРИЛТ 6: Санхүүгийн салбарын долларжилтыг бууруулах.

ЗОРИЛТ 7: Санхүүгийн хүчтэй тогтолцоотой болох, хөрөнгийн зах зээлийн хөгжлийг эрчимжүүлэх. Арилжааны банкны эрсдэл удирдах чадвар, үр ашиг, засаглалыг сайжруулах хүрээнд:

ЗОРИЛТ 8: Зээлийн мэдээллийн сан, зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааг өргөжүүлэх.

ЗОРИЛТ 9: Зээлийн эрсдэлийг бууруулах чиглэлээр хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох.

ЗОРИЛТ 10: Банкны үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх.

ЗОРИЛТ 11: Төрийн болон банк, санхүүгийн байгууллагын засаглалыг сайжруулах, санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах.

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХҮҮНД НӨЛӨӨЛЖ БУЙ ХҮЧИН ЗҮЙЛ: ЭМПИРИК БАРИМТУУД


Хадгаламж, зээлийн хүү нь санхүүгийн байгууллагын шийдвэрээс хамаарах хэдий ч энэхүү шийдвэрт зах зээлийн бүтэц, санхүүгийн салбарын хөгжил, дэд бүтцийн хөгжил, хууль, эрх зүйн орчин, санхүү, макро эдийн засгийн тогтвортой байдал, мөнгөний бодлогын үр нөлөөтэй байдал зэрэг олон хүчин зүйл тусгалаа олж байдаг. Эдгээр хүчин зүйл нь улс орнуудад зээлийн хүү яагаад ялгаатай байгааг тайлбарлах учиртай. Манай орны хувьд зээлийн хүү өндөр байгаа нь судлаач, бодлого боловсруулагчдын анхаарлын төвд байж, судалсаар ирсэн нэг гол сэдэв юм. Тухайлбал, Зээл, хадгаламжийн хүүний зөрүүнд: (1) макро эдийн засгийн эрсдэл (инфляци, эдийн засгийн өсөлт, валютын ханш); (2) банк хоорондын захын хүү, түүний хэлбэлзэл; (3) зээлийн эрсдэл буюу чанаргүй зээл; (4) валютын ханшийн эрсдэл; (5) зээл, хадгаламжийн зах зээл дэх төвлөрөл, өрсөлдөөний бүтэц (Herfindahl-ийн индекс, төвлөрлийн харьцаа); (6) санхүүгийн зах зээлийн ерөнхий хөгжил (банкны актив/ДНБ, хөрөнгийн захын үнэлгээ/ДНБ); (7) заавал байлгах нөөцийн хувь; (8) өөрийн хөрөнгийн зохистой харьцааны шалгуур (эрсдэлийг хумих арга хэмжээ); (9) банкны үйл ажиллагааны зардал; (10) банкны хүүний бус цэвэр зардал; (11) орлого оруулдаг активын нийт активд эзлэх хувь; (12) банкны удирдлагын үр чадвар буюу нийт орлого, зардлын харьцаа; (13) банкны өргөжилтийн үр өгөөж

(economy of scale) буюу нэгж зээл, эсвэл хадгаламжид ногдох зардал зэрэг нөлөөлдөг байна (Д. Ган-Очир 2006, 2009, 2016). Зээлийн хүүнд нөлөөлөгч макро, микро хүчин зүйл нь яагаад зээлийн хүүг өндөр түвшинд хадгалагдахад нөлөөлж буй суурь хүчин зүйлийг дурдвал:

- Манай орны эдийн засаг гадаад цочролд хэт өртөмтгий;
- Нийлүүлэлтийн хүчин зүйлээс хамаарч инфляци нь тогтворгүй, өндөр байсан;
- Макро эдийн засгийн бодлого нь тогтворгүй, мөчлөг дагаж хэрэгжсэн;
- Гадаад валютын нөөц багатай, улсын өр өндөр түвшинд хүрсэн;
- Санхүүгийн тогтвортой байдал хэврэг байсаар өдийг хүрсэн;
- Санхүүгийн зах зээл дээрх Төв банкны оролцоо хэт их байсан;
- Банкны үйл хөдлөл нь мөчлөг дагасан шинжтэй байсан;
- Дотоод хуримтлал багатайгаас депозитын зах зээл дээрх эх үүсвэрийн төлөөх өрсөлдөөн хүчтэй;
- Санхүүгийн бизнес хийх ерөнхий эрсдэл өндөр;
- Институц, засаглалын чанар сул зэрэг болно.

Иймд зээлийн хүүг бууруулах бодлогын арга хэмжээ нь: (i) хүү буурах макро эдийн засгийн тогтвортой орчныг бүрдүүлэх; (ii) бодлогын хүүний хадгаламж, зээлийн хүүнд үзүүлэх нөлөөг сайжруулах; (iii) микро хүчин зүйл буюу арилжааны банкны эрсдэл даах чадвар, үр ашиг, засаглалыг сайжруулах гэсэн ерөнхий гурван том стратегийн зорилтод төвлөрөх

**ТҮҮХИЙ ЭДИЙН ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭ
(АМ.ДОЛЛАРААР, 28/ҮШ ӨДРИЙН БАЙДЛААР)**





Кенийн Сенатын танхим

КЕНИ УЛС ЗЭЭЛИЙН ХҮҮНДЭЭ ХЯЗГААР ТАВЬСНААР ЭДИЙН ЗАСАГТАА ТУШАА БОЛЖ БАЙНА

Энэ удаагийн дугаарын Дэлхийн эдийн засаг булангаар Африк тивийн зүүн эрэг дагуу орших Бүгд Найрамдах Кени Улсад зээлийн хүүд хязгаар тогтоосон хууль болон түүний үр нөлөөний талаар мэдээлэхээр зорилоо. 49.7 сая хүн амтай Кени Улс нь экваторын бүс орчим оршдог трофикийн уур амьсгалтай улс бөгөөд 2017 оны мэдээгээр ДНБ 74.9 сая ам.долларт хүрчээ. Чийглэг уур амьсгал, далайд гарцтай тус улсын эдийн засгийн 35 орчим хувийг газар тариалан, хөдөө аж ахуй, 17 орчим хувийг аж үйлдвэр, уул уурхайн салбар, 45 орчим хувийг аялал жуулчлал, үйлчилгээний салбар тус тус бүрдүүлдэг аж. 2016 оны 3-р

сард 989.8 сая ам.доллар бүхий 24 сарын хугацаатай ОУВС-ийн Стэнд Бай хөтөлбөрт хамрагдсан бөгөөд тус хөтөлбөрийг Кенийн талын хүсэлтээр 2018 оны 3-р сард дахин 6 сараар сунгасан. Хөтөлбөрийг сунгахад тавьсан үндсэн нөхцөлүүдийн нэг нь хүүгийн хязгаарлалтыг эргэн харах байсан юм.

Кени Улсын эдийн засаг 2017 онд 4.9 орчим хувь өссөн ч энэ нь сүүлийн 5 жилийн хугацаанд хамгийн бага үзүүлэлт аж. Эдийн засгийн хурд ийнхүү саарах болсон гол шалтгаан нь нэгдүгээрт зээлийн нийлүүлэлт буурсан, хоёрдугаарт 2017 онд борооны улирал удаан үргэлжилснээс болж хөдөө аж ахуйн салбарын бүтээмж болон

эрчим хүчний нийлүүлэлт буурсан зэргээс голлон шалтгаалжээ. Тэр дундаа 2016 онд зээлийн хүүд хязгаарлалт тавьсан нь 2014 онд 25%-д хүрээд байсан зээлийн нийлүүлэлтийн өсөлтийг 2017 оны 8-р сард 1.6 хувь хүртэл буурсан нь өнгөрсөн 10 жилийн хамгийн бага үзүүлэлт юм. Ийнхүү зээлийн нийлүүлэлт 7 орчим тэрбум ам.доллар буюу ДНБ-ний 10%-тай тэнцэхүйц хэмжээгээр буурсан нь эдийн засагт хүндрэлийг бий болгоод байна.

Кени нь Африк тивийн хөгжиж байгаа орнуудын нэг. 2010 онд үндсэн хуулиндаа нэмэлт өөрчлөлт оруулснаар улс төр, нийгэм, эдийн засаг, бүтцийн томоохон өөрчлөлтүүдийг эхлүүлээд байгаа. Олон тулгуурт

эдийн засагтай, ажиллах хүчний хэмжээнд залуучуудын эзлэх хувь өндөр тул дотоод нөөц бололцоотой хөгжиж байгаа орны тоонд багтдаг. Харин 2016 оны 8-р сард Кенийн Сенатаас Банкны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, зээлийн хүүг хамгийн дээд тал нь Төв банкны бодлогын хүүнээс 400 бүхэл нэгж хувиар өндөр байхаар баталжээ. Өнөөгийн байдлаар Кенийн Төв банкны бодлогын хүү 9.0% байгаа бөгөөд тус хуулийн дагуу банкны зээлийн хүүг хамгийн дээд тал нь 13.0%-д тогтоож болох аж.

Нөгөө талаас тус нэмэлт өөрчлөлтөөр зээлийн хүүд тааз тогтоохоос гадна хадгаламжийн хүүнд шал буюу доод хязгаарыг тогтоож өгсөн байна. Ингэхдээ арилжааны банкны хадгаламжийн хүүг хамгийн багадаа Төв банкны бодлогын хүүний 70%-тай тэнцэхүйц түвшинд байлгах заалт оруулжээ. Энэ нь өнөөгийн байдлаар 6.3% билээ. Хадгаламж гэдэг бол зээл олгох эх үүсвэр байдаг учраас хадгаламжийн хүүг бууруулах замаар зээлийн хүүг бууруулах боломжтой ч хадгаламжийн хүүд шал тогтоож өгснөөр харин ч эсрэгээр, зардлыг нэмэгдүүлж, эдийн засагт хүндрэл үүсгээд байгааг дараах үр нөлөөнөөс харж болно.



ХУУЛИЙН ҮР НӨЛӨӨ

Кенийн Төв банкны мэдээллээр арилжааны банкууд дахь дундаж зээлийн хэмжээ 1 жилийн хугацаанд 36.7 хувиар өссөн нь зээл олголт буурсантай шууд холбоотой юм. Зээлийн дундаж дүн өссөнөөр чанаргүй зээлийн хэмжээ нэмэгдэх эрсдэл үүсдэг. Дэлхийн банкны судалгаанаас үзэхэд Кенийн банкууд дахь чанаргүй зээлийн түвшин 8%-аар өссөн нь энэ бүхнийг батална. Гэхдээ энд тэмдэглэж хэлэхэд чанаргүй зээлийн хэмжээ өсөхөд голлон нөлөөлсөн өөр нэг шалтгаан нь зээлийн хүүд тааз тогтоосны улмаас банкууд шинээр олгох зээлийн эргэн төлөлтийн хугацааг богиносгосон явдал юм. Зээлийн эргэн төлөлтийн хугацаа богиносох үед зээлдэгч нарт ирэх дарамт нэмэгддэг ба цаашлаад зээлийн эргэн төлөлт хоцрох, эсвэл бүр дефолтод орох эрсдэлтэй.

Хадгаламжийн хүүг өндөрт барихтай зэрэгцээд зээлийн

хүүг бууруулснаар банкуудын олох ашиг буурдаг ба үүнийг тойрч гарах өөр нэг арга зам нь хүүгийн бус хураамжуудыг нэмэгдүүлэх аж. Кенид өнгөрсөн хугацаанд яг ийм үзэгдэл болсон ба банкны үйлчилгээний шимтгэл хураамжууд 2017 онд 15.2%-аар нэмэгдсэн. Өөрөөр хэлбэл зээлийн хүү буурсан мэт боловч банкны харилцагчдын төлөх шимтгэл, хураамжууд ерөнхийдөө өссөн байна.

Кенийн Төв банкны мэдээгээр чанаргүй зээлийн түвшин өсч байгаа ч банкуудын нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын харьцаа дунджаар 15.8%, 18.4% байгаа нь зохистой харьцааны шалгуур болох 10.5%, 14%-аас харьцангуй өндөр байгаа нь санхүүгийн тогтвортой байдал хангагдаж байгааг харуулж байна. Гэхдээ зээлийн хүү, хадгаламжийн хүү хоорондын зөрүү багассанаар жижиг банкууд алдагдалтай ажиллах, мөн банкууд зээл гаргах бус Засгийн газрын үнэт цаас

худалдаж авах идэвхи нэмэгдсэн.

Өөр нэг томоохон нөлөө ажиглагдсан нь зээлийн хүүд тааз тогтоосноор мөнгөний бодлогын үр нөлөөг бууруулах эрсдэлийг үүсгэсэн. 2016 оны 9-р сарын Кенийн Төв банкны мөнгөний бодлогын хорооны хуралдаанаар цаашид инфляци буурах төлөвтэй байгааг хэлэлцсэн. Мөн зээл олголт хувийн секторт огцом буурах эрсдэлтэй байгааг үндэслэж бодлогын хүүг 0.5 хувиар бууруулан 10.0%-д хүргэсэн. Харамсалтай нь тус шийдвэрээс үл хамаарч зээл олголт үргэлжлэн буурч, эдийн засагт сөргөөр нөлөөлөөд байна. Тиймээс ч Кенийн Төв банкнаас зээлийн хүүд хязгаар тогтоож байгаа цагт зорилтоо бүрэн хангах баталгаа байхгүйг мэдэгдсэн. Учир нь хүүгийн таазыг бодлогын хүүтэй уясан үед бодлогын хүүг бууруулахад, зээлийн хүү дагаад буух учир зээлийн нийлүүлэлтэд үзүүлэх нөлөө багатай аж.

БАНКНЫ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАХИН ХЭЛЭЛЦЭВ

Зээлийн хүүд хязгаар тавих нь зээлийн хүүг бууруулах нөлөөтэй мэт боловч үнэн хэрэгтээ зээлийн хүртээмжийг бууруулж, зээл авахад хүндрэлтэй болгодог болохыг Кенийн жишээнээс харж болох юм. Дэлхийн банкнаас 76 орчим улсад зээлийн хүүд ямар нэг байдлаар хязгаар тавьсныг тэмдэглэжээ. Тэдгээрт зарим сайн

туршлагауд байгаа боловч эдийн засагтаа сөрөг нөлөө үзүүлж байгаа нь олон. Ялангуяа Кенийн хувьд хоёр жилийн хугацаанд аль хэдийн хүндрэлүүд бий болоод эхэлсэн учраас Дэлхийн банк, ОУВС зэрэг байгууллагаас энэ хуулийн заалтыг цуцлахыг анхааруулж, хэрэгжүүлж байгаа хөтөлбөрийн зайлшгүй хангах нөхцөлүүдийн нэгээр заагаад байгаа. Нөгөө талаас Кенийн Төв банк, Сангийн яамнаас ч ОУВС-ийн зөвлөмжийг дагах эрмэлзэлтэй ч гол шийдвэрийг Сенатаас гаргана.

Хүлээсний эцэст зүүн Африкийн хамгийн том эдийн засагтай улсын Сенат Банкны тухай хуулийн 33В заалтыг 8 сард дахин хэлэлцлээ. Эцсийн шийдвэрийг гаргах мөчид “Зээлийн хүүгийн таазыг Төв банкны бодлогын хүүнээс дээш 400 бүхэл нэгж хувиар тогтооно” гэсэн заалтыг хассан боловч оронд нь “Зээлийн хүүгийн таазыг Төв банкны лавлах хүүнээс (Reference Rate) дээш 400 бүхэл нэгж хувиар тогтооно” гэсэн шинэ заалт оруулжээ. Өөрөөр хэлбэл өнөөдөр Кенийн Төв банкны лавлах хүү 7.6 хувь байгаа тул зээлийн хүүг дахин буулгаж 11.6 хувьд хүргэсэн явдал боллоо. Энэ нь хүлээлтээс эсрэг шийдвэр болж, зах зээлийг доргиосон. Энэ үед Сенатаас гаргасан өөр нэг шийдвэр нь хадгаламжийн хүүний шалыг авч хаясан явдал юм.

Хадгаламжийн хүүнд тавих хязгаарлалтыг авсан ч зээлийн хүүгийн хязгаарлалт улам чангарлаа. Зээлийн хүүг бууруулснаар жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих мэт сэдэл өгдөг ч үнэн хэрэгтээ тэдэнд зээл олголт буурч, зээлийн хүртээмж саарснаар мөнгөөр улам их дутагтдаг. Кенийн улс төрчдөөс популист хандлага ажиглагдаж байгаа ба иргэдэд таалагдах гэж оролдож байгаа ч эдийн засагтаа тушаа болж байна. Зээлийн хүүд тааз тогтоосноор хувийн секторт зээл гаргалт буурсан ч эсэргээрээ төрийн секторын зээлийн хэмжээ өсчээ.

Жич: Энэхүү нийтлэлд дурьдах аливаа дүгнэлт, дэвшүүлсэн санал нь зөвхөн нийтлэлчийн байр суурь ба Монголбанкны байр суурийг илэрхийлэх албагүй.

Эх сурвалж:

1. World Bank. Private Sector Credit Growth is Key to Kenya's Economic Recovery. December 6, 2017
2. Central Bank of Kenya. Impact of Interest Rate Capping on the Kenyan Economy. March, 2018.
3. Safavian M, Zia B. World Bank. The Impact of Interest Rate Caps on the Financial Sector: Evidence from Commercial Banks in Kenya (Policy Research Working Paper 8393). April, 2018.
4. Mbogo A. The Kenyan Wall Street Journal. <https://kenyanwallstreet.com/parliament-maintains-rate-cap-law-in-favour-of-borrowers>. August 27, 2018.

БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА БА ЯАГААД БИД БАНКТАЙ ХАРИЛЦДАГ ВЭ?

1. НАЙДВАРТАЙ ХАДГАЛАМЖ

Хэрэв банк байхгүй бол хүмүүс мөнгөө өөрсдөө хадгалж, эрсдэлээ өөрсдөө үүрнэ.

Харин банк бий болсноор мөнгөө найдвартай газарт хадгалуулах боломж бүрдсэн.

Банкинд хүмүүс мөнгөө өгч эхэлсэн нь банкны анхны функцуудын нэг болох хадгаламжийн үйлчилгээ юм.

2. ТӨЛБӨР ТООЦООНЫ СИСТЕМ

Банк нь нэг харилцагчаас нөгөө банкинд эсвэл өөр банкны харилцагчдад мөнгөн шилжүүлгийг гүйцэтгэдэг. Энэ төрлийн үйл ажиллагааг бэлэн бус төлбөр тооцоо гэж нэрлэдэг. Төлбөр тооцооны систем нэвтэрснээр цаг хугацаа, зардал хэмнэх төдийгүй эдийн засаг дахь мөнгөний эргэлтийг хурдасгах, нийт эдийн засаг болон санхүүгийн салбарт хийгдэж буй төлбөр тооцоог тасралтгүй, найдвартай, шуурхай гүйцэтгэнэ.

3. ХӨРӨНГИЙГ ХУВААРИЛАХ

Мөнгөтэй хүний хөрөнгийг санхүүжилт шаардлагатай байгаа хэсэгт зуучлах.

Банк нь зээл, хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүнээрээ дамжуулан бизнес эрхлэгчид, хувь хүмүүст санхүүжилтийг тодорхой нөхцөлөөр хангаж ажилладаг.

Банк, түүний бүтээгдэхүүн үйлчилгээ, хэрэглээ

Монгол Улс 2 шатлал бүхий банкны системтэй бөгөөд дараах 3 төрлийн банк үйл ажиллагаа явуулж байна. Иргэд зөвхөн арилжааны банкаар үйчлүүлдэг

учраас Төв банк, Хөгжлийн банкнийг арилжааны банктай адилтгаж ойлгох тохиолдол бишгүй бий.

Гэтэл банкнийг өмчийнх нь хэлбэрээр төрийн, хувийн, төрийн өмчийн оролцоотой банк гэж тус тус ангилдаг.

Монголбанк, Монгол Улсын Хөгжлийн банк, Арилжааны банкуудын үндсэн үүрэг, ялгаа

•ТӨРИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭД

- Мөнгөн тэмдэгт гүйлгээнд гаргах;
- Мөнгөний бодлого боловсруулж, хэрэгжүүлэх;
- Арилжааны банкны үйл ажиллагаанд хяналт тавих;
- Банк хоорондын төлбөр тооцоог зохион байгуулах;
- Гадаад валютын улсын нөөцийг эзэмшиж удирдах;
- Засгийн газрын санхүүгийн зуучлалын үүрэг гүйцэтгэх.

МОНГОЛБАНК



•АШГИЙН ТӨЛӨӨ ТӨРИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭД

- Хөгжлийн томоохон төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх;
- Үнэт цаас гаргах, худалдах, худалдан авах;
- Өөрийн нэрийн өмнөөс зээлийн баталгаа батлан даалт гаргах;
- Гадаад валют арилжаа, зээлтэй холбоотой төлбөр тооцоо.

МОНГОЛ
УЛСЫН
ХӨГЖЛИЙН
БАНК



•АШГИЙН ТӨЛӨӨ ХУУЛИЙН ЭТГЭЭД

- Зээл, хадгаламж;
- Гадаад валют арилжаа, төлбөр тооцоо;
- Үнэт цаас гаргах, худалдах, худалдан авах;
- Үнэт зүйл, металл хадгалах;
- Өөрийн нэрийн өмнөөс баталгаа, батлан даалт гаргах;
- Санхүүгийн бусад хэрэгслийг худалдах, худалдан авах;
- СЗХ-оос зөвшөөрөлтэй-гээр даатгалын зуучлал, андеррайтер, кастодиан гэх мэт үйл ажиллагаа.

АРИЛЖААНЫ
БАНК



Арилжааны банк нь харилцах, хадгаламж татах, зээл олгох, төлбөр тооцоо хийх үндсэн үйлчилгээ үзүүлдэг. Орчин үед харилцагчдынхаа цаг хугацаа, ажлыг хөнгөвчлөх үүднээс бүтээгдэхүүн үйлчилгээгээ цахимжуулж, интернэт банк, мобайл банк, олон төрлийн карт, орлого, зарлага, мөнгөн шилжүүлэг хийдэг бэлэн мөнгөний машин зэрэг олон үйлчилгээг чанарын өндөр түвшинд үзүүлж байна. Мөн харилцагчдадаа санхүүгийн зөвлөгөө мэдээлэл өгөх үйлчилгээнд их анхаарч байна.

Банкнаас дараах бүтээгдэхүүн үйлчилгээг авч хэрэглэж болно.

Банк санхүүгийн асуудлаар үйлчлүүлэгчдэдээ зөвлөгөө өгөх, санхүүгийн тусгай бүтээгдэхүүн санал болгодог. Банкны бүтээгдэхүүн үйлчилгээ нь зориулалт, харилцагчдын хэрэгцээ шаардлагад нийцүүлсэн байдлаасаа хамааран маш олон төрөлтэй байдаг.



Харилцах данс нь байгууллагын болон иргэдийн гэж байдаг. Харилцах дансанд тооцогдох хүү хадгаламжийн данстай харьцуулахад харьцангуй бага байдаг.

Хадгаламжийн данс нь хугацаатай болон хугацаагүй гэж ерөнхий ангилагддаг.

Зээлийг хэрэглээний, бизнесийн мөн орон сууцны гэж ангилдаг.

Картыг зөвхөн хугацаагүй хадгаламж болон харилцах дансандаа авах боломжтой байдаг. Дотоодын карт болон олон улсын карт гэж байдаг.

АТМ буюу Бэлэн мөнгөний машин нь банкны ажилтнаас авдаг байсан үйлчилгээг хүссэн үедээ

өөртөө үйлчлэн авах боломжийг олгож байна.

Мобайл банк гар утсандаа банкны аппликейшн суулгаад дансны үлдэгдэл болон хуулгаа шалгах, банк дотроо болон өөр банк хооронд мөнгө шилжүүлэх, зээлээ төлөх, гар утас болон байрны төлбөр төлөх, валютын ханшийн мэдээлэл авах зэрэг банкны үйлчилгээг авах боломжтой.

Интернэт банкны үйлчилгээ нь заавал банкинд очихгүй интернэтийн сүлжээтэй орчинд байвал банкны бүхий л төрлийн үйлчилгээг өөрөө авах боломжийг олгож байна.

НАЙМДУГААР САРД 2,866 КГ АЛТ ХУДАЛДАН АВЛАА

Монголбанк 2018 оны 8 дугаар сард 2,866 кг алт худалдан авсан байна.

Тэгвэл 2018 оны эхний 8 сард 12.2 тонн алт худалдан авсан нь өмнөх оны мөн үед 12.2 тонн алт авч байсантай адил үзүүлэлттэй байна.

2018 оны 8 дугаар сарын байдлаар 1 грамм алт худалдан авах Монголбанкны дундаж үнэ 95,042.34 төгрөг байлаа.




График 1. 1990-2018 онд Монголбанкны худалдан авсан алтны хэмжээ



График 2. 2018 оны 8 дугаар сард Монголбанкны алт худалдан авсан үнэ

ВАЛЮТ АРИЛЖААНЫ ЦАХИМ ТАЛБАРЫН АРИЛЖААНЫ ТОЙМ

БХВАЦТ-ыг 2017/4/10-нд нэвтрүүлсэнээс хойш 2018/8/29-ний хооронд 474,1 сая ам.долларын болон 110.4 сая юанийн нийт 819 удаагийн арилжаа БХВАЦТ-т хийгдээд байна.






МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

ЭХ ОРНЫХОО

АЛТЫГ ЭРДЭНЭСИЙН САНДАА АЯН

2018.06.04-2018.10.30



www.mongolbank.mn



[@mongolbank.mn](https://twitter.com/mongolbank.mn)



[Mongolbank.mn](https://www.facebook.com/Mongolbank.mn)



[Mongolbankmn](https://www.youtube.com/Mongolbankmn)